

Агуулга

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал	3
I. Нийгмийн үзүүлэлт	6
1. Хүн ам	6
2. Бүртгэлтэй ажилгүй иргэд	6
3. Нийгмийн эмзэг бүлэг	8
4. Нийгмийн даатгал, халамж.....	9
5. Боловсрол	11
6. Эрүүл мэнд	13
7. Гэмт хэрэг	14
II. Макро эдийн засгийн хандлага.....	16
1. Дотоодын нийт бүтээгдэхүүн	16
2. Үнэ	17
3. Мөнгө, зээл, үнэт цаас	22
4. Улсын нэгдсэн төсөв.....	26
5. Гадаад худалдаа	28
III. Үйлдвэрлэл, үйлчилгээ	31
1. Бизнес регистр	31
2. Мал аж ахуй	31
3. Газар тариалан	34
4. Аж үйлдвэр	35
5. Барилга	36
6. Дотоод худалдаа	37
7. Тээвэр	38
8. Шуудан, холбоо	41
9. Хилээр нэвтэрсэн зорчигчид	41
IV. Бусад	42
1. Цаг уур, агаарын бохирдолт	42
V. Хавсралт хүснэгтүүд	44
VI. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүтэц болон ААНБ-ын тооллогын үндсэн үр дүн.....	76
VII. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм	87

Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.



**Монгол Улсын нийгэм,
эдийн засгийн байдал
(2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр)**

I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2011 онд 70328 эх амаржиж, өмнөх оныхоос 4668 эх буюу 7.1 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 70576 болж, 4687 хүүхэд буюу 7.1 хувиар өслөө.

Улсын хэмжээнд 2011 онд нэг хүртэлх насандаа 1152 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 123 хүүхэд буюу 9.6 хувь, 1-5 хүртэлх насны 258 хүүхэд эндэж, 89 хүүхэд буюу 25.6 хувиар буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2011 оны жилийн эцэст 57.2 мянга болж, өмнөх оныхоос 18.9 мянга хүнээр буюу 49.5 хувиар өсчээ.

Бүх шатны сургуульд суралцагчдын тоо 2011/2012 оны хичээлийн жилийн эхэнд 890.6 мян.хүн болж, өмнөх оныхоос 40.1 мян.хүн буюу 4.7 хувиар нэмэгдэв.

Бүх шатны сургуулийг 2010/2011 оны хичээлийн жилд 133.7 мян.суралцагчид төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 86.7 мян.сурагч (9-р ангийг 51.9 мянга, 11-р ангийг 33.1 мянга), мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг 11.2 мян.суралцагчид, их, дээд сургууль, коллежийг 35.8 мян.оюутан төгсчээ.

Нийгмийн даатгалд 2011 онд 653.5 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 429.0 мянга буюу 65.6 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагынх, 224.5 мянга буюу 34.4 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оныхоос нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 77.6 мянга буюу 13.5 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 72.3 мянга буюу 20.3 хувь, төсөвт байгууллагынх 5.3 мянга буюу 2.4 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2011 онд 56.8 мян.хүн хамрагдсан нь өмнөх оныхоос 141 хүн буюу 0.2 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 7.5 тэрбум төг буюу 26.8 хувиар нэмэгджээ.

“Хүний хөгжил” сангаас 2011 онд 733.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.8 сая иргэнд олгожээ.

Халдварт өвчнөөр 2011 онд 42.8 мян.хүн өвчилж, өмнөх оныхоос 1466 хүн буюу 3.5 хувиар нэмэгдсэн нь өвчлөгчдийн тоо гар, хөл, амны өвчнөөр 1543 хүн буюу 59.7 хувь, мөөгөнцөр өвчнөөр 2221 хүн буюу 49.8 хувь, цусан суулгаар 1331 хүн буюу 38.6 хувь, трихомониазаар 623 хүн буюу 13.5 хувь, гонококкт халдвараар 582 хүн буюу 10.1 хувь, сүрьеэгээр 228 хүн буюу 5.4 хувиар буурсан хэдий ч вирүст гепатитаар 5573 хүн буюу 61.2 хувь, салхин цэцгээр 1829 хүн буюу

2.4 дахин, гахайн хавдраар 492 хүн буюу 93.4 хувь, тэмбүүгээр 331 хүн буюу 8.4 хувиар нэмэгдсэнээс голлон шалтгаалав.

Улсын хэмжээнд 2011 онд 19197 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 628 хэргээр буюу 3.2 хувиар буурчээ. Үүнд өмнөх оныхоос тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (231), нийгмийн аюулгүй байдлын эсрэг (189), захиргааны журмын эсрэг (52), байгаль хамгаалах журмын эсрэг, шүүн таслах ажиллагааны эсрэг тус бүр (39), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг (24) зэрэг гэмт хэрэг нэмэгдсэн хэдий ч өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (712), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (351), хүн амын эрүүл мэндийн эсрэг (67), аж ахуйн эсрэг (43) зэрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2011 онд 8100 хүн гэмтэж, 922 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 614 буюу 8.2 хувиар өсч, нас барсан хүний тоо 269 буюу 22.6 хувиар буурсан байна.

II.Макро эдийн засгийн үзүүлэлт

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 10829.7 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4881.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 27.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 17.3 хувиар тус тус өслөө.

ДНБ-ий 2011 оны бодит өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 42.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 16.0 хувь, барилгын салбарынх 14.3 хувь, уул уурхай, олборлох салбарынх 8.7 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлж байна.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 10899.9 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4906.5 тэрбум төг болж, өмнөх оныхоос оны үнээр 2440.3 тэрбум төг буюу 28.8 хувь, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 723.5 тэрбум төг буюу 17.3 хувиар өслөө. Уг өсөлтөд нийт хуримтлалын өсөлт голлон нөлөөлсөн байна.

2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр тооцсон ДНБ-д эцсийн хэрэглээ 64.4 хувь, нийт хуримтлал 58.1 хувь, цэвэр экспорт -22.5 хувийг эзэлж, өмнөх оныхоос эцсийн хэрэглээ 2.6 пункт, цэвэр экспорт 14.9 пунктээр тус тус буурч, харин хөрөнгийн нийт хуримтлал 17.5 пунктээр өссөн байна.



Бүтцийн энэ өөрчлөлтөд 2011 онд үндсэн хөрөнгийн хуримтлал өссөн нь голлон нөлөөлж байна.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 2.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувиар өслөө. Инфляцийн жилийн дундаж түвшин 9.2 хувь байв. Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 3.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2011 оны эцэст 6427.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 304.0 тэрбум төг буюу 5.0 хувь, өмнөх оныхоос 1747.2 тэрбум төг буюу 37.3 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2011 оны эцэст 713.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 34.4 тэрбум төг буюу 5.1 хувь, өмнөх оныхоос 193.7 тэрбум төг буюу 37.3 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны эцэст 5641.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 202.4 тэрбум төг буюу 3.7 хувь, өмнөх оныхоос 2376.4 тэрбум төг буюу 72.8 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны эцэст 73.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 2.2 тэрбум төг буюу 3.1 хувиар өсч, өмнөх оныхоос 16.9 тэрбум төг буюу 18.7 хувиар буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2011 оны эцэст 330.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 13.2 тэрбум төг буюу 3.8 хувь, өмнөх оныхоос 44.4 тэрбум төг буюу 11.9 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжааг 2011 онд 252 өдөр явуулж, 350.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 125.6 сая ш үнэт цаас арилжсан байна.

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4400.6 тэрбум төг, үүнээс тогтворжуулалтын сангийн орлого 241.0 тэрбум төг болж, нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн хэмжээ 4159.6 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4792.0 тэрбум төгрөгт хүрч, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 632.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн урсгал орлого 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4141.3 тэрбум төг, урсгал зардал 3234.4 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 906.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Татварын нийт орлого өмнөх оныхоос 948.6 тэрбум төг буюу 35.3 хувиар нэмэгдэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн орлогын албан татвар 367.3 тэрбум төг буюу 86.8 хувиар буурсан

хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 563.2 тэрбум төг буюу 65.1 хувь, бусад татварын орлого 262.2 тэрбум төг буюу 84.7 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 154.4 тэрбум төг буюу 39.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 144.1 тэрбум төг буюу 74.5 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 119.1 тэрбум төг буюу 36.0 хувь, хүн амын орлогын албан татварын орлого 69.7 тэрбум төг буюу 43.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оныхоос 114.4 тэрбум төг буюу 29.3 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 33.4 тэрбум төг буюу 60.5 хувь, төсөвт газрын өөрийн орлого 22.1 тэрбум төг буюу 13.5 хувь, хүү, торгуулийн орлого 21.4 тэрбум төг буюу 59.2 хувь, газрын тосны орлого 21.2 тэрбум төг буюу 38.7 хувь, бусад нэр заагдаагүй орлого 12.8 тэрбум төг буюу 26.8 хувь, навигацын орлого 3.5 тэрбум төг буюу 11.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4792.0 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1711.3 тэрбум төг буюу 55.6 хувиар нэмэгдсэн нь зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 5.0 тэрбум төг буюу 11.8 хувиар буурсан хэдий ч татаас, шилжүүлгийн зардал 621.4 тэрбум төг буюу 59.3 хувь, хөрөнгийн зардал 476.1 тэрбум төг буюу 80.6 хувь, бараа, үйлчилгээний зардал 361.8 тэрбум төг буюу 31.0 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 257.1 тэрбум төг буюу 2.1 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардалд 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1067.2 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оныхоос 476.1 тэрбум төг буюу 80.6 хувиар нэмэгджээ. Энэ нь дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 454.1 тэрбум төг буюу 80.9 хувь, гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 22.0 тэрбум төг буюу 74.9 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Манай улс 2011 онд урьдчилсан байдлаар дэлхийн 127 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 11307.2 сая ам.долл, үүнээс экспорт 4780.4 сая ам.долл, импорт 6526.9 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 онд 291.6 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 39.3 сая ам.долл буюу 15.6 хувиар нэмэгдэж байсан бол гадаад худалдааны тэнцэл 2011 онд урьдчилсан байдлаар 1746.5 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 1455.0 сая ам.долл буюу 6.0 дахин өсчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 5198.7 сая ам.долл, үүнээс импортын хэмжээ



3326.8 сая ам.долл экспортын хэмжээ 1871.8 сая ам.доллараар өсчээ.

Экспортын 98.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна.

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Улсын хэмжээгээр 2011 оны эцэст 36.3 сая толгой мал, үүний дотор 2112.9 мян. адуу, 2339.7 мян. үхэр, 280.1 мян. тэмээ, 15668.5 мян. хонь, 15934.6 мян. ямаа тоологдов.

Малын нийт тоо өмнөх оныхоос 3.6 сая буюу 11.0 хувиар өссөний дотор адуу 192.6 мянга буюу 10.0 хувь, үхэр 163.7 мянга буюу 7.5 хувь, тэмээ 10.5 мянга буюу 3.9 хувь, хонь 1.2 сая буюу 8.2 хувь, ямаа 2.1 сая буюу 14.8 хувиар өсчээ.

Оны эхэнд тоологдсон нийт малын 2.0 хувь буюу 0.7 сая том мал 2011 онд зүй бусаар хорогдов.

2011 онд 446.1 мян. т үр тариа, 201.6 мян. т төмс, 99.0 мян. т хүнсний ногоо хурааж, 1195.2 мян. т хадлан, 46.7 мян. т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос хураасан үр тариа 91.0 мян. т буюу 25.6 хувь, төмс 33.7 мян. т буюу 20.1 хувь, хүнсний ногоо 16.7 мян. т буюу 20.3 хувь, хадлан 58.0 мян. т буюу 5.1 хувь, гар тэжээл 14.0 мян. т буюу 42.8 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2011 онд 2056.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 182.2 тэрбум төг буюу 9.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд газрын тос, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 16.8-77.3 хувь, нарийн боов, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, малын мах, талх, амтат ус, ундаа, шингэн сүү, тамхи, архи, жүүс, шар айраг, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.8-86.5 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Барилга угсралт, их засварын ажил 2011 онд 450.7 тэрбум төг болж, 427.9 тэрбум төг буюу 94.9 хувь нь дотоодын, 22.8 тэрбум төг буюу 5.1 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна. Барилга угсралт, их засварын ажил өмнөх оныхоос 99.9 тэрбум төг буюу 28.5 хувиар өсөхөд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажил 101.4 тэрбум төг буюу 31.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Бүх төрлийн тээврээр 2011 онд 44.0 сая т ачаа, давхардсан тоогоор 296.2 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос тээсэн ачаа 14.5 сая т буюу 49.5 хувь, зорчигчдын тоо 45.5 сая хүн буюу 18.2 хувиар нэмэгджээ.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2011 оны 12 дугаар сард Завхан аймгийн Тосонцэнгэл суманд (6.0 мм) орсон байна. Энэ оны 12 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их температур -0.6 хэм, Завхан аймгийн Тосонцэнгэл суманд хамгийн бага температур -43.1 хэм байлаа. Салхины хурд Архангай аймгийн Цэцэрлэг суманд 16 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2011 оны 12 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол, 32-ын тойрог орчимд тус бүр 31 удаа, Баруун дөрвөн замын орчимд 27 удаа, Офицеруудын ордон орчимд 18 удаа, 1-р хороолол орчимд 16 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 13-р хороолол, 32-ын тойрог, Хархорин захын орчимд тус бүр 31 удаа, Офицеруудын ордон орчимд 20 удаа, Баруун дөрвөн замын орчимд 19 удаа, 1-р хороолол орчимд 16 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 28 удаа, 32-ын тойрог орчимд 26 удаа, Баруун дөрвөн замын, орчимд 22 удаа, Хархорин захын орчимд 16 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 23 удаа, 13-р хороолол орчимд 4 удаа, угаарын хий 32-ын тойрог орчимд 5 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Аюулт үзэгдэл, осол 2011 онд 3548 удаа гарсны улмаас 213 хүн амь насаа алдаж, 165.5 мян. толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Аюулт үзэгдэл ослыг төрлөөр нь авч үзвэл объектын түймэр 3063 удаа, ой, хээрийн түймэр 161 удаа, гол, нуурын усанд унасан осол 93 удаа, мал, тэжээвэр амьтны галзуу өвчин 47 удаа, 3.5-аас дээш магнитудын газар хөдлөлт 39 удаа, бичил уурхай, нурангины осол 22 удаа, аадар бороо, үер 18 удаа, хүчтэй салхи, шуурга 15 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2011 онд 9.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.



I. Нийгмийн үзүүлэлтүүд

Зураг-I.1

I.1 Хүн ам

Монгол улсын хүн амын тоо 2011 оны жилийн эцсийн байдлаар урьдчилсан дүнгээр 2834.2 мянга болж, оны эхнээс 53.4 мянган хүн буюу 1.9 хувиар өслөө.

Эрүүл мэндийн яамны захиргааны статистикийн мэдээгээр 2011 онд 70.3 мянган эх амаржиж, 70.6 мянган хүүхэд мэндэлсэн байна. Амаржсан эхийн тоо 2011 онд өмнөх оныхоос 7.4 мянгаар буюу 11.7 хувиар нэмэгдэв.

1000 хүн амд ногдох төрөлт 2011 оны жилийн эцсийн байдлаар 24.9, нас баралт 6.0, хүн амын цэвэр өсөлт 18.9 байна (Зураг I.1). Төрөлтийн түвшин 2011 онд нэмэгдэж, нас баралт буурснаас хамаарч хүн амын цэвэр өсөлт 2.6 пунктээр өссөн байна.

1000 хүн амд ногдох төрөлт 2011 онд Говьсүмбэр, Ховд, Дорнод, Дархан-Уул, Орхон аймаг болон Улаанбаатаар хотод улсын дунджаас 0.3-4.6 пунктээр дээгүүр, бусад аймагт улсын дунджаас 0.2-14.7 пунктээр доогуур байна.


1000 хүн амд ногдох нас баралт Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Орхон, Сүхбаатар, Дорнод, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.1-1.0 пунктээр дээгүүр, бусад аймагт улсын дунджаас 0.1-1.5 пунктээр доогуур байна.

I.2 1. Бүртгэлтэй ажилгүй иргэн*

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2011 оны жилийн эцэст 57.2 мянга болж, өмнөх оныхоос 18.9 мянга хүнээр буюу 49.5 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 26.0 мянга буюу 45.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оныхоос 7.0 пунктээр буурчээ. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 33.3 мянга буюу 58.2 хувь нь 16-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Ховд, Дархан-Уул, Дундговь, Төв, Өвөрхангай, Хэнтий, Өмнөговь, Баянхонгор, Сэлэнгэ, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Орхон, Сүхбаатар аймагт улсын дунджаас 1.2-19.6 пунктээр их байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1.0 хувь нь магистр, доктор, 21.1 хувь нь дипломын болон бакалаврын, 6.9 хувь тусгай мэргэжлийн дунд, 7.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 45.9 хувь нь бүрэн дунд, 13.4 хувь нь суурь, 3.5 хувь нь бага, 0.9 хувь нь боловсролгүй иргэд байна (Зураг I.2).

1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, жил бүрийн эцсийн байдлаар




Эх сурвалж: Эрүүл мэндийн яамны мэдээлэл

Хүн амын ердийн цэвэр өсөлт Увс, Говьсүмбэр, Дорнод, Баян-Өлгий, Дархан-Уул, Ховд, Орхон аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.1-4.2 пунктээр дээгүүр, бусад аймагт улсын дунджаас 0.2-13.6 пунктээр доогуур байна.

Зураг-I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2011 оны жилийн эцсийн байдлаар, хувиар



**Ажлын шинэ байр ***


Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэдээгээр ажлын шинэ байр 2011 онд 73.2 мянган бий болжээ. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 31.9 мянга буюу 43.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт ажлын шинэ байрны 55.6 мянга буюу 75.9 хувийг байнгын, 17.6 мянга буюу 24.1 хувийг улирлын чанартай ажлын байр эзэлж байна. Ажлын шинэ байрыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 18.2 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 17.7 хувь нь барилгын салбарт, 12.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 12.1 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 12.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 9.9 хувь нь уул уурхай, олборлолтын, 3.2 хувь нь боловсролын, 14.4 хувь нь бусад салбарт ногдож байна (Зураг 1.3)

Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг насны ангиллаар авч үзэхэд 15.7 мянга нь буюу 21.5 хувь 15-24, 23.8 мянга нь буюу 32.5 хувь 25-34, 18.1 мянга нь буюу 24.7 хувь 35-44, 14.4 мянга нь буюу 19.7 хувь 45-59, 1.2 мянга нь буюу 1.6 хувь 60, түүнээс дээш насны хүмүүс байна. (Зураг 1.4).


Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл 2.9 хувь нь менежерийн, 9.6 хувь нь мэргэжилтэн, 2.5 хувь нь техникч болон туслах мэргэжилтэн, 2.1 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 15.8 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 15.4 хувь нь хөдөө аж ахуй, загас агнуурын ажилтан, 22.6 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох үйлчилгээний ажилтан, 7.4 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 21.5 хувь нь энгийн ажил мэргэжил, 0.2 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй хүмүүс байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг насны ангиллаар авч үзэхэд 15.7 мянга нь буюу 21.5 хувь 15-24, 23.8 мянга нь буюу 32.5 хувь 25-34, 18.1 мянга нь буюу 24.7 хувь 35-44, 14.4 мянга нь буюу 19.7 хувь 45-59, 1.2 мянга нь буюу 1.6 хувь 60, түүнээс дээш насны хүмүүс байна. (Зураг 1.5).


Зураг-1.3

Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 оны жилийн эцсийн байдлаар

Зураг-1.4

Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 оны жилийн эцсийн байдлаар

Зураг-1.5


Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, насны бүлгээр, 2011 оны жилийн эцсийн байдлаар

* Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр



Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл 2.9 хувь нь менежерийн, 9.6 хувь нь мэргэжилтэн, 2.5 хувь нь техникч болон туслах мэргэжилтэн, 2.1 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 15.8 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 15.4 хувь нь хөдөө аж ахуй, загас агнуурын ажилтан, 22.6 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох үйлчилгээний ажилтан, 7.4 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 21.5 хувь нь энгийн ажил мэргэжил, 0.2 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй хүмүүс байна.

Зураг-1.6




1.3 Нийгмийн эмзэг бүлэг

Улсын хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2011 онд нийт 40.8 мянга болж, 4.3 мянга буюу 10.6 хувь нь бүтэн өнчин, 36.5 мянга буюу 89.4 хувь нь хагас өнчин хүүхдүүд байна. Сүүлийн жилүүдэд өнчин хүүхдийн тоо буурах хандлага ажиглагдаж байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо 2011 онд өмнөх оныхоос 351 хүүхдээр буюу 7.5 хувиар, хагас өнчин хүүхдийн тоо 1702 хүүхэд буюу 4.5 хувиар багасчээ (Зураг 1.6).

Зураг-1.7

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо, ам бүлийн тоогоор, жилийн эцсийн байдлаар



Нийт өнчин хүүхдийн 5.3 мянга буюу 13.0 хувь нь 0-6 насны, 7.6 мянга буюу 18.6 хувь нь 7-9 насны, 17.0 мянга буюу 41.8 хувь нь 10-15 насны, 10.8 мянга буюу 26.6 хувь нь 16-18 насны хүүхдүүд байна.

Байгалийн гамшигт өртсөн хүүхдийн тоо 2011 онд 6 болж, өмнөх оныхоос 112 хүүхдээр, амиа хорлох оролдлого хийсэн хүүхдийн тоо 3 болж, 2 хүүхдээр буурсан байна. Харин зам, тээврийн болон ахуйн осолд өртсөн хүүхдийн тоо 80 болж, 14 хүүхдээр, халдварт өвчин, тахалд нэрвэгдсэн хүүхдийн тоо 118 болж, 54 хүүхдээр нэмэгдсэн бөгөөд тэдгээрийн нийт дүнд 0-6 насны хүүхдийн эзлэх хувь өмнөх оныхоос 5.7 пунктээр, 7-9 насны хүүхдийнх 0.6 пунктээр буурч, харин 10-15 насны хүүхдийнх 1.6 пунктээр, 16-18 насны хүүхдийнх 4.6 пунктээр өсчээ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2011 онд 81.4 мянга болж, өмнөх оныхоос 636 хүн буюу 0.8 хувиар өсч, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн тоо 29.4 мянга болж, өмнөх оныхоос 1050 хүн буюу 3.7 хувиар нэмэгджээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоог өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 271 хүн буюу 0.3 хувиар нэмэгджээ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 46.5 мянга буюу 57.1 хувь нь 3 хүртэлх, 27.6 мянга буюу 33.9 хувь нь 3-5, 7.3 мянга буюу 9.0 хувь нь 6, түүнээс дээш ам бүлтэй байна (Зураг 1.7). Өрх толгойлсон эрэгтэйчүүд 29.4 мянга болж, 19.2 мянга буюу 65.4 хувь нь 3 хүртэлх, 7.7 мянга буюу 26.2 хувь нь 3-5, 2.5 мянга буюу 8.4 хувь нь 6, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тэргүүлэгч байна.

Улсын хэмжээнд 8, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо 2011 оны эцэст 13.9 мянга болж, өмнөх оныхоос 567 өрхөөр буюу 3.9 хувь, 16 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй



өрхийн тоо 24.1 мянга болж, 7 өрхөөр буюу 0.03 хувиар буурчээ (Зураг I.8).

Ганцаар амьдардаг өндөр настай хүний тоо 23.1 мянга болж, өмнөх оныхоос 68 хүн буюу 0.3 хувиар нэмэгдэв. Үүнээс 7.3 мянга нь 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүд; 15.9 мянга нь 55, түүнээс дээш насны эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2011 онд 86.9 мянга болж, өмнөх оныхоос 4400 хүн буюу 5.1 хувиар өсч, үүнээс 45.9 хувь нь эмэгтэйчүүд, 79.9 хувь нь хөдөлмөрийн насны иргэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 32.5 хувь нь төрөлхийн, 67.5 хувь нь олдмол үүнээс 70.9 хувь нь ердийн өвчнөөс, 11.1 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 14.5 хувь нь ахуйн ослоор, 3.5 хувь нь үйлдвэрлэлийн ослоос болжээ.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.1 мянга буюу 10.4 хувь нь харах эрхтний, 10.0 мянга буюу 11.5 хувь нь сонсгол хэл ярианы, 16.2 мянга буюу 18.6 хувь нь хөдөлгөөний согогтой, 10.6 мянга буюу 12.2 хувь нь оюун ухааны хомсдолтой, 8.8 мянга буюу 10.1 хувь нь сэтгэцийн эмгэгтэй, 9.8 мянга буюу 11.3 хувь нь хавсарсан согогтой, 22.4 мянга буюу 25.8 хувь нь бусад хэлбэрийн согогтой байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2011 онд 8.2 мянга болж, нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.5 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 406 буюу 5.2 хувиар нэмэгджээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 64.0 хувь нь төрөлхийн, 36.0 хувь нь олдмол байна.

I.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын сангийн орлого 2011 онд 763.3 тэрбум төг, зарлага 607.1 тэрбум төг болж, өмнөх оныхоос орлого 156.8 тэрбум төг буюу 25.9 хувь, зарлага 75.7 тэрбум төг буюу 14.2 хувиар нэмэгдлээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2011 онд өмнөх оныхоос 156.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 16.1 тэрбум төг буюу 54.3 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 9.6 тэрбум төг буюу 48.6 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн орлого 113.1 тэрбум төг буюу 27.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



Нийгмийн даатгалын сангийн зарлага 75.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 5.4 тэрбум төг буюу 38.5 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 10.9 тэрбум төг буюу 10.7 хувиар буурсан хэдий ч, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 7.1 тэрбум төг буюу 28.6 хувь, тэтгэврийн даатгалын сангийн зарлага 81.6 тэрбум төг буюу 22.0 хувь, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 3.3 тэрбум төг буюу 17.6 хувиар өссөн нь нөлөөлөв.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2011 онд 440.6 тэрбум төг болсны 74.5 хувийг өндөр настны, 12.2



хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.9 хувийг цэргийн, 6.4 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оныхоос өндөр настны тэтгэвэр 23.7 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр 18.7 хувь, цэргийн тэтгэвэр 25.3 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 10.5 хувиар өсчээ. (Зураг I.10).

Нийгмийн даатгалд 2011 онд 653.5 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 429.0 мянга буюу 65.6 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 224.5 мянга буюу 34.4 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оныхоос нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 77.6 мянга буюу 13.5 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 72.3 мянга буюу 20.3 хувь, төсөвт байгууллагынх 5.3 мянга буюу 2.4 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамж:

Нийгмийн халамжийн сангаас 2011 онд 174.5 мян.хүнд 67.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оныхоос нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 5.5 мян.хүн буюу 3.1 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 13.9 тэрбум төг буюу 25.9 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 48.8 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 32.6 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 9.0 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 8.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 1.1 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөж буй иргэд байна. (Зураг I.11).


Нийгмийн халамжийн сангаас 2011 онд олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 35.4 тэрбум төг буюу 52.3 хувийг халамжийн тэтгэвэрт, 20.7 тэрбум төг буюу 30.7 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 5.6 тэрбум төг буюу 8.3 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 5.2 тэрбум төг буюу 7.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асарч буй иргэдэд, 724.9 сая төг буюу 1.1 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна.(Зураг I.12).

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2011 онд 56.8 мян.хүн хамрагдсан нь өмнөх оныхоос 141 хүн буюу 0.2 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 7.5 тэрбум төг буюу 26.8 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 422.5 мян.хүн хамрагдсаны


Зураг-I.10

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, 2011 оны жилийн эцсийн байдлаар, хувиар




Зураг-I.11

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2011 оны жилийн эцсийн байдлаар, хувиар



Зураг-I.12

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2011 оны жилийн эцсийн байдлаар, хувиар





28.8 хувь нь ахмад настан, 1.1 хувь нь алдар цолтой ахмад настан, 11.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 51.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 7.0 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

Алдарт эхийн одонтой 189.6 мянган эхчүүдэд 2011 онд 29.7 тэрбум төгрөгийн тусламж олгосон байна.

“Хүний хөгжил” сангаас 2011 онд 733.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.8 сая иргэнд олгожээ.

I.5. Боловсрол


Бүх шатны сургуульд суралцагчдын тоо 2011/2012 оны хичээлийн жилийн эхэнд 890.6 мян.хүн болж, өмнөх оныхоос 40.1 мян.хүнээр буюу 4.7 хувиар нэмэгдэв.(Зураг I.13)

Бүх шатны сургуулийг 2010/2011 оны хичээлийн жилд 133.7 мян.суралцагчид төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 86.7 мян.сурагч (9-р ангийг 51.9 мянга, 11-р ангийг 33.1 мянга), мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг 11.2 мян.суралцагчид, их, дээд сургууль, коллежийг 35.8 мян.оюутан төгсчээ. (Зураг I.14)

Улсын хэмжээнд 2011/2012 оны хичээлийн жилд 879 цэцэрлэгт 164.3 мян.хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оныхоос цэцэрлэгийн тоо 40-өөр буюу 4.8 хувиар, хүүхдийн тоо 42.2 мянга буюу 34.6 хувиар өссөн байна. Цэцэрлэгийн бүлгийн тоо 5253 болж, өмнөх оныхоос 55-аар буюу 1.1 хувиар нэмэгдлээ.

Ерөнхий боловсролын 752 сургуульд 2011/2012 оны хичээлийн жилд 505.4 мян. сурагчид суралцаж байгаа нь өмнөх оныхоос сургуулийн тоо 1-ээр буюу 0.1 хувиар нэмэгдэж, суралцагчдын тоо 6.8 мян.буюу 1.3 хувиар буурав. Нийт суралцагчдын 256.5 мянга нь 1-5 дугаар ангид, 169.2 мянга нь 6-9 дүгээр ангид, 79.6 мянга нь 10-12 дугаар ангид суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оныхоос 1.1 хувиар өсч, Өмнөговь аймагт өмнөх оны түвшинд, харин бусад аймагт 0.4-4.8 хувиар буурлаа. 2011/2012 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 46.7 мян.хүүхэд элсэн орсон нь өмнөх оныхоос 0.2 мян.хүүхдээр буюу 0.4 хувиар өсчээ. Дотуур байранд нийт



38.1 мян.сурагч амьдарч байгаагийн 19.9 мян.буюу 52.2 хувь нь эмэгтэй, 32.8 мян буюу 86.1 хувь нь малчдын хүүхэд байна. “Үдийн цай” хөтөлбөрт 2011 онд 1-5 дугаар ангийн нийт 256.6 мян.хүүхэд хамрагдаж, 16.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгджээ. Энэ хичээлийн жилд 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 нэр төрлийн 1312.8 мян.ш сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан суралцагчдад олгосон байна.

2011/2012 оны хичээлийн жилд мэргэжлийн



сургалт үйлдвэрлэл (МСҮ)-ийн 71 төв үйл ажиллагаа явуулж байгаагийн 49 нь төрийн өмчийн, 22 нь хувийн өмчийн сургууль байна. Нийт МСҮТ-ийн бие даасан 40 нь , коллежийн харьяа 9, дээд сургуулийн харьяа 7, их сургуулийн харьяа 15 төв байна. Энэ хичээлийн жилд МСҮ-ийн 2 төв шинээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 2011/2012 оны хичээлийн жилд МСҮТ-д 48.1 мян. суралцагчид суралцаж байгаа нь өмнөх оныхоос 2.0 мянга буюу 4.3 хувиар нэмэгдсэн байна. 2011/2012 оны хичээлийн жилд суурь боловсрол эзэмшигчдийн 21.4 хувь нь МСҮТ-д элсэн суралцаж байна.

2011/2012 оны хичээлийн жил нийт 101 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаагийн 15 нь төрийн өмчийн, 81 нь төрийн өмчийн бус, 5 нь гадаадын сургуулийн салбар байна. Улаанбаатар хотод 92, хөдөө орон нутагт 9 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна. Их, дээд сургууль, коллежийн тоо өмнөх оныхоос 12-оор буурчээ. Их, дээд сургууль, коллежид 172.8 мян. оюутан суралцаж байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилийнхээс 2.7 мян.буюу 1.6 хувиар нэмэгдсэн байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 154.9 мянга буюу 89.6 хувь нь бакалаврын түвшний сургалтад хамрагдаж байна.


Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 61.1 мянга буюу 35.3 хувь нь нийгмийн ухааны, 32.6 мянга буюу 18.9 хувь нь техник, технологийн, 22.4 мянга буюу 13.0 хувь нь боловсролын, 16.0 мянга буюу 9.2 хувь нь анагаах ухааны, 14.8 мянга буюу 8.6 хувь нь хүмүүнлэгийн, 12.0 мянга буюу 6.9 хувь нь байгалийн шинжлэх ухааны, 8.0 мян.буюу 4.7 хувь нь үйлчилгээний салбар, 5.3 мянга буюу 3.0 хувь нь хөдөө аж ахуйн, 0.7 мянга буюу 0.4 хувь нь бусад салбарын мэргэжлээр суралцаж байна. Засгийн газар хоорондын хоёр талын гэрээ хэлэлцээрийн дагуу 2011/2012 оны хичээлийн жилд БНХАУ-д 315, ОХУ-д 298, Турк улсад 94, Япон улсад 60, Энэтхэг улсад 30, Польш улсад 21, Вьетнам улсад 15, Чех улсад 7, Лаос улсад 5, Казакстан улсад 5, Унгар улсад 5, БНСУ-д 3, Украин улсад 3, Болгар улсад 2, Куба улсад 2, БНАСАУ-д 2

нийт 16 орны их, дээд сургууль, коллежид 867 оюутан элсэн суралцсан байна.

2010/2011 оны хичээлийн жилд нийт 35.8 мян.оюутан төгссөн нь өмнөх оныхоос 4.7 хувиар нэмэгдэв. Нийт төгсөгчдийн 64.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Төгсөгчдийн 40.6 хувь нь нийгмийн шинжлэх ухааны, 5.9 хувь нь байгалийн шинжлэх ухааны, 16.1 хувь нь багш, сурган хүмүүжүүлэх, 11.7 хувь нь инженер, техник, технологийн, 8.9 хувь нь хүмүүнлэгийн ухаан, урлагийн, 8.7 хувь нь эрүүл мэндийн, 2.2 хувь нь хөдөө аж ахуйн, 5.9 хувь нь үйлчилгээний салбарын мэргэжлээр төгссөн нь өмнөх оныхоос хөдөө аж ахуй, хүмүүнлэгийн мэргэжлээр төгсөгчдийн тоо 1.6-9.1 хувиар буурч, харин эрүүл мэнд, байгалийн ухаан, багш сурган хүмүүжүүлэх, техник, технологийн мэргэжлээр төгсөгчдийн тоо 4.4-15.0 хувиар өссөн байна.

Цэцэрлэгийн нэг багшид ногдох сурагчийн тоо 2011/2012 оны хичээлийн жилд 33.5 болж, өмнөх оныхоос 7 хүүхдээр буюу 27.4 хувиар өссөн бол Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нэг багшид ногдох оюутны тоо 2011/2012 оны хичээлийн жилд 23.0 болж, өмнөх оныхоос 1 хүүхдээр буюу 7.0 хувиар өсчээ. ЕБС-ийн нэг багшид ногдох сурагчийн тоо, Их, дээд сургууль, коллежийн нэг багшид ногдох оюутны тоо 2011/2012 оны хичээлийн жилд өмнөх оныхтой ижил түвшинд байна. (Зураг I.15)

Зураг-I.15





I.6. Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2011 онд 70328 эх амаржиж, өмнөх оныхоос 4668 эхээр буюу 7.1 хувиар, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 70576 болж, 4687 хүүхэд буюу 7.1 хувиар өслөө (Зураг I.16). Харин 2011 оны 12 дугаар сард 5666 хүүхэд амьд төрж, өмнөх оныхоос 650 хүүхэд буюу 13.0 хувиар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2011 онд нэг хүртэлх насандаа 1152 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 123 хүүхэд буюу 9.6 хувь, 1-5 хүртэлх насны 258 хүүхэд эндэж, 89 хүүхэд буюу 25.6 хувиар буурчээ (Зураг I.17). Энэ хугацаанд жирэмслэлт болон төрөлтийн улмаас 34 эх эндсэн нь өмнөх оныхоос 4 эх буюу 13.3 хувиар нэмэгдсэн байна.


Нэг хүртэлх насандаа 2011 оны 12 дугаар сард 97 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 3 хүүхэд, 1-5 хүртэлх насандаа 28 хүүхэд эндэж, 2 хүүхдээр буурсан байна. Жирэмслэлт болон төрөлтийн улмаас 2011 оны 12 дугаар сард 5 эх эндэж, өмнөх оны мөн үеийнхтэй ижил төвшинд байна.

Улсын хэмжээнд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2011 онд 16 болж, өмнөх оныхоос 3 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Хөвсгөл (30), Өвөрхангай (27), Төв (27), Баян-Өлгий (25), Говь-Алтай (24), Завхан (23), Увс (23) аймагт улсын дунджаас 7-14 хүүхдээр, Өмнөговь (20), Дорнод (20), Баянхонгор(19), Сүхбаатар (19), Хэнтий (19), Ховд (18) аймагт 2-4 хүүхдээр илүү байна.


1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насандаа* эндсэн хүүхдийн тоо 2011 онд 20 болж, өмнөх оныхоос 5 хүүхдээр буурчээ. Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 2011 оны 12 дугаар сард 125 болж, өмнөх оныхоос 5 хүүхдээр буурсан байна.

Халдварт өвчнөөр 2011 онд 42.8 мян.хүн өвчилж, өмнөх оныхоос 1466 хүн буюу 3.5 хувиар нэмэгдсэн нь өвчлөгчдийн тоо гар, хөл, амны өвчнөөр 1543 хүн буюу 59.7 хувь, мөөгөнцөр өвчнөөр 2221 хүн буюу 49.8 хувь, цусан суулгаар 1331 хүн буюу 38.6 хувь, трихомониазаар 623 хүн буюу 13.5 хувь, гонококкт халдвараар 582 хүн буюу 10.1 хувь, сүрьеэгээр 228 хүн буюу 5.4 хувиар буурсан хэдий ч вирүст гепатитаар 5573 хүн буюу 61.2 хувь, салхин цэцгээр 1829 хүн буюу 2.4 дахин, гахайн хавдраар 492 хүн буюу 93.4 хувь, тэмбүүгээр 331 хүн буюу 8.4 хувиар нэмэгдсэнээс голлон шалтгаалав.


Зураг-I.16



Зураг-I.17



Зураг-I.18



Халдварт өвчнөөр 2011 оны 12 дугаар сард 4411 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 221 хүн буюу 4.8 хувиар буурахад гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 185 хүн буюу 31.1 хувь, вирүст гепатитээр өвчлөгчдийн тоо 125 хүн буюу 5.7 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 80 хүн буюу 22.8 хувиар буурсан нь нөлөөлжээ.

10 000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2011 онд улсын дунджаар 151 болж, өмнөх оныхоос 2 хүнээр нэмэгдсэн байна (Зураг I.18).




ХДХВ/ДОХ-ын 17 тохиолдол илэрч улсын хэмжээнд ХДХВ/ДОХ-ын нийт 100 тохиолдол 2011 онд бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2011 онд нийт 17127 хүн нас барсан нь өмнөх оныхоос 149 хүн буюу 0.9 хувиар буурчээ (Зураг I.19). Эмнэлэгт нас барсан хүний тоо 2011 онд 4176 болж, өмнөх оныхоос 21 хүн буюу 0.5 хувиар буурсан байна. Энэ нь нийт нас баралтын 24.4 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо 2011 оны 12 дугаар сард 1403 болж, өмнөх оны мөн үеийнхээс 59 хүн буюу 4.0 хувиар буурав.

Эмнэлэгт 2011 онд нийт 694.2 мян.хүн хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оныхоос 14484 хүн буюу 2.1 хувиар нэмэгджээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2011 оны 12 дугаар сард 65.2 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 4903 хүн буюу 8.1 хувиар өсөв.

Хувийн эмнэлгүүд 2011 онд 1393.7 мян.хүнд үйлчилж, 39.2 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр

Зураг-I.19



үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оныхоос 31.8 хувиар өсч, төлбөрт үйлчилгээний хэмжээ 2.3 дахин нэмэгдлээ.

Тайлбар: * Тав хүртэлх насны хүүхдэд 0-4 нас 364 хүртэл хоногтой хүүхдийг хамруулав.


I.7. Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2011 онд 19197 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 628 хэргээр буюу 3.2 хувиар буурчээ (Зураг I.20). Үүнд өмнөх оныхоос тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (231), нийгмийн аюулгүй байдлын эсрэг (189), захиргааны журмын эсрэг (52), байгаль хамгаалах журмын эсрэг, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг тус бүр (39), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг (24) зэрэг гэмт хэрэг нэмэгдсэн хэдий ч өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (712), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (351), хүн амын эрүүл мэндийн эсрэг (67), аж ахуйн эсрэг (43) зэрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 56.1 хувь нь нийслэлд, 42.9 хувь нь аймгуудад, 0.7 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.3 хувь нь бусад газарт 2011 онд бүртгэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос Хөвсгөл аймагт 15.8 хувь, Завхан аймагт 8.8 хувь, Хэнтий аймагт 8.5 хувь, Өвөрхангай аймагт 7.7 хувь, Төв аймагт 7.4 хувь, Өмнөговь аймагт 2.9 хувь, Булган аймагт 2.5 хувь, Дорноговь аймагт 2.2 хувиар нэмэгдэж, харин Сэлэнгэ аймагт 22.5 хувь, Дорнод аймагт 21.5 хувь, Баянхонгор аймагт

Зураг-I.20



20.4 хувь, Архангай аймагт 15.9 хувь, Говь-Алтай аймагт 14.9 хувь, Дундговь аймагт 10.8 хувь, Дархан-Уул аймагт 9.3 хувь, Баян-Өлгий аймагт 8.7 хувь, Орхон аймагт 6.8 хувь, Увс аймагт 6.7 хувь, Ховд аймагт 4.7 хувь, Сүхбаатар аймагт 3.7 хувь, Улаанбаатар хотод 0.8 хувиар буурсан бол Говьсүмбэр аймагт өмнөх оны түвшинд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 420 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 136 хэрэг буюу 47.9 хувиар нэмэгдсэн байна. Малын хулгайн 1169 гэмт хэрэг бүртгэгдэн нийт гэмт хэргийн 6.1 хувийг эзэлж, өмнөх оныхоос 99 хэрэг буюу 9.3 хувиар өсчээ.



Бүртгэгдсэн гэмт хэргийн 46.3 хувийг хүндэвтэр, 41.6 хувийг хөнгөн, 9.5 хувийг хүнд, 2.6 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оныхоос хөнгөн хэргийнх 0.5 пункт, онц хүнд хэргийнх 0.4 пунктээр нэмэгдэж, хүнд хэргийнх 0.7 пункт, хүндэвтэр хэргийнх 0.2 пунктээр буурсан байна (Зураг I.21).

Зураг-I.21

Улсын дунджаар 2011 онд 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд 104 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оныхоос 7 хэрэг буюу 6.3 хувиар буурав.

Түүнчлэн сэжигтэн нь тодорхойгүй байсан 6504 хэргийн 3999 буюу 61.5 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оныхоос улсын хэмжээнд 1.6 пунктээр нэмэгдэв. (Зураг I.22).

Хүүхэд оролцсон хэрэг 2011 онд өмнөх оныхоос 29.7 хувь, бүлэглэн үйлдсэн хэрэг 5.4 хувиар өсч, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 6.5 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 2.5 хувиар буурчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2011 онд 17982 байгаагийн 1163 буюу 6.5 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 2303 буюу 12.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 5.5 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оныхоос 1.0 пунктээр өсчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад ажилчин, малчдын эзлэх хувь 2011 онд 17.4 болж, өмнөх оныхоос 2.0 пункт, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагчдынх 7.6 хувь болж 0.4 пункт, оюутан, сурагчдынх 6.8 хувь болж 0.5 пункт, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 6.6 хувь болж 0.4 пунктээр нэмэгдэж, харин ажилгүй иргэдийн эзлэх хувь 56.1 болж 1.3 пункт, төрийн албан хаагчдынх 3.7 хувь болж 1.6 пункт, төрийн бус байгууллагын ажиллагчдынх 1.0 хувь болж, 0.2 пунктээр буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар нь авч үзэхэд 2011 онд 31.1 хувь нь гэр, орон сууцанд, 18.3 хувь нь гудамж, талбайд, 14.0 хувь нь олон нийтийн газарт, 9.3 хувь нь авто замд, 6.0 хувь нь аж ахуйн нэгжид, 2.2 хувь нь төрийн байгууллагад, 1.6 хувь нь төрийн бус байгууллагад, 1.1 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 16.4 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн ангиллаар, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар



Зураг-I.22

Гэмт хэргийн илрүүлэлт, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар



Зураг-I.23

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, 2011 оны эцсийн байдлаар, хувиар






Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2011 онд 8100 хүн гэмтэж, 922 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 614 буюу 8.2 хувиар өсч, нас барсан хүний тоо 269 буюу 22.6 хувиар буурсан байна (Зураг I.24).


Зураг-I.24

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2011 онд 35.9 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 18.5 тэрбум төг болж, өмнөх оныхоос учирсан хохирлын хэмжээ 2.5 тэрбум төг буюу 7.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 4.1 тэрбум төг буюу 28.9 хувиар өссөн байна (Зураг I.18). Нийт нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 4.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төрийн өмчит байгууллагын нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 1.7 тэрбум төгрөг, хувийн өмчит байгууллагынх 2.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 70.8 хувь буюу 25.4 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.



Зураг-I.25

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2011 онд 18592 байгаагийн 1178 буюу 6.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 6856 буюу 36.9 хувь нь эмэгтэйчүүд байна.



Харин гэмт хэргийн улмаас нийт 184 байгууллагад хохирол учирсны 128 нь төрийн, 14 нь төрийн бус, 42 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2011 онд 115.3 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 12.4 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оныхоос эрүүлжүүлэгдсэн хүний тоо 5.6 мянга буюу 5.1 хувиар, баривчлагдсан хүний тоо 1.7 мянга буюу 15.6 хувиар өссөн байна.

II.Макро эдийн засгийн хандлага

Зураг-II.1


II.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), үйлдвэрлэлийн аргаар

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 10829.7 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4881.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 2415.2 тэрбум төгрөг буюу 28.7 хувь, зэрэгцүүлэх үнээр 718.6 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар өслөө (Зураг II.1).

ДНБ-ий 2011 оны бодит өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 42.5 хувь, боловсруулах аж

ДНБ-ий жилийн өсөлт, бууралт, хувиар, өмнөхон=100





үйлдвэрийн салбарынх 16.0 хувь, барилгын салбарынх 14.3 хувь, уул уурхай, олборлох салбарынх 8.7 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлж байна. Мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2011 онд өмнөх оныхоос 0.3 хувиар өслөө.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт оны үнээрээ 2011 онд өмнөх оныхоос 55.7 хувь, түүнчлэн импорт өмнөх оныхоос 2 дахин өссөн нь тус салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар оны үнээр 2011 онд өмнөх оныхоос 91.4 хувь, онцгой албан татвар 9.5 хувь, гадаад худалдааны татвар 74.5 хувь тус тус нэмэгдсэн нь бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 65.6 хувь өсөхөд голлон нөлөөлжээ.

2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 10899.9 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4906.5 тэрбум төг болж, өмнөх оныхоос оны үнээр 2440.3 тэрбум төг буюу 28.8 хувь, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 723.5 тэрбум төг буюу 17.3 хувиар өслөө. Уг өсөлтөд нийт хуримтлалын өсөлт голлон нөлөөлсөн байна.

2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр тооцсон ДНБ-д эцсийн хэрэглээ 64.4 хувь, нийт хуримтлал 58.1 хувь, цэвэр


2. Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхтай харьцуулахад 2.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувиар өслөө (Хүснэгт1). Инфляцийн жилийн дундаж түвшин 9.2 хувь байв.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувь өссөний дотор хүнсний барааны бүлгийн үнэ 8.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааных 8.9 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 13.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 14.1 хувь, тээврийнх 16.1 хувь,

ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтэц, оны үнээр



* урьдчилсан гүйцэтгэл

экспорт -22.5 хувийг эзэлж, өмнөх оныхоос эцсийн хэрэглээ 2.6 пункт, цэвэр экспорт 14.9 пунктээр тус тус буурч, харин хөрөнгийн нийт хуримтлал 17.5 пунктээр өссөн байна (Зураг II.2).

Бүтцийн энэ өөрчлөлтөд 2011 онд үндсэн хөрөнгийн хуримтлал өссөн нь голлон нөлөөлж байна.

боловсролын үйлчилгээнийх 11.9 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 11.2 хувь өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд эдгээрээс бусад бүлгийн үнэ 0.3-7.1 хувиар өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 3.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ болон боловсролын үйлчилгээний бүлгийн дүн тогтвортой байсан бөгөөд харин эдгээрээс бусад бүлгийн дүн 0.1-1.8 хувиар өсчээ.



Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр


Хүснэгт-II.1

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2011 XII	2011 XII
		2010 XII	2011 XI
Ерөнхий индекс	100,0	110,2	102,0
Хүнсний бараа, ундаа, ус	39,7	108,2	103,8
Согтууруулах ундаа, тамхи	2,8	103,3	100,5
Хувцас, бөс бараа, гутал	15,3	113,9	101,8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10,8	114,1	100,2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5,6	108,9	100,5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1,8	103,5	101,1
Тээвэр	9,0	116,1	100,1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2,9	100,3	100,0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3,0	107,1	100,0
Боловсролын үйлчилгээ	5,4	111,9	100,0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	1,0	107,0	100,5
Бусад бараа, үйлчилгээ	2,7	111,2	100,6

Хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны 12 дугаар сард оны эхнээс 13.0 хувиар өссөн бол 2011 оны 12 дугаар сард 10.2 хувь болж, өсөлт 2.8 пунктээр буурчээ (Зураг II.3).

Зураг-II.4

Зураг-II.3




Хэрэглээний үнийн сарын индекс улсын дүнгээр 2011 оны 3, 4, 8 дугаар сард өмнөх сарынхаас 0.2-0.8 хувиар буурч, бусад сард 0.4-3.0 хувиар өссөн байна. Хэрэглээний үнэ 2011 онд 1 дүгээр сард хамгийн их буюу 3.0 хувиар өсч, харин 3 дугаар сард хамгийн их (-0.8%) буурчээ (Зураг II.4).

Зураг-II.5

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс бүх аймагт 5.3-14.2 хувиар өссөн байна. Үнийн өсөлт Завхан, Архангай, Хэнтий, Говь-Алтай, Дундговь, Хөвсгөл, Өмнөговь, Булган, Увс, Дорноговь, Дорнод аймагт улсын дунджаас 0.2-4.0 пунктээр илүү байлаа (Зураг II.5).

Хэрэглээний үнийн индекс, нийслэл, аймгаар, 2011 оны жилийн эцэст, (өмнөх оны 12 сар =100%)





Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 2011 оны эцэст өмнөх оныхоос бүх аймагт 17.8-62.0 хувиар өссөний дотор Дорнод (60.0%), Ховд (62.0%) аймагт өссөн нь өндөр өсөлт байв.

Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ Баян-Өлгий (18.5%), Хэнтий (6.6%), Дундговь (5.2%), Сэлэнгэ (2.9%), Сүхбаатар (1.0%) аймагт буурч, бусад 16 аймагт 0.2-15.1 хувиар өссөний дотор Говь-Алтай (9.8%), Завхан (15.1%) аймагт өссөн нь өндөр өсөлт байлаа.

Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ Өвөрхангай (16.0%), Баянхонгор (14.9%), Сэлэнгэ (13.9%), Архангай (8.5%), Завхан (4.9%), Орхон (2.6%), Баян-Өлгий (2.4%) аймагт буурч бусад 14 аймагт 0.3-18.7 хувиар өссөний дотор Дорнод аймагт 18.7 хувиар өссөн нь өндөр үзүүлэлт байв.

Төмс, хүнсний ногооны үнэ 11 аймагт буурсны дотор Ховд (16.5%), Орхон (16.2%) аймагт байгаа нь хамгийн их бууралт байв. Харин Баянхонгор (7.5%), Сэлэнгэ (12.7%), Баян-Өлгий (12.9%), Дундговь (13.2%), Дорноговь (14.3%), Увс (15.1%), Архангай (16.8%), Хөвсгөл (17.7%), Говьсүмбэр (19.8%), Булган (23.3%) аймагт өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 12 дугаар сард өмнөх сартай харьцуулахад бүх аймагт 0.5-6.0 хувиар өссөн байна.

Сүхбаатар аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхтай харьцуулахад 6.0 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ өсөлтөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.2 хувь, үүний дотор сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 35.0 хувь, мах, махан бүтээгдэхүүнийх 9.4 хувь, төмс, хүнсний ногооных 6.3 хувь, жимс, жимсгэнийх 17.7 хувь, ундаа, жүүснийх 7.2 хувь түүнчлэн согтууруулах ундаа, тамхиных 4.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 10.7 хувь, гэр ахуйн тавилга, барааных 2.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 11.1 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн ерөнхий индекс Улаанбаатар хотод 2011 оны 12 дугаар сард өмнөх оны эцсийнхээс 11.1 хувь өссөний дотор тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 21.9 хувь, хувцас, гутал, бөс барааных 17.5 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 13.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 11.6 хувь, боловсролын үйлчилгээнийх 10.2 хувь, хүнсний бараа, ундаа, усны бүлгийнх 8.9 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 8.7 хувь, гэр ахуйн бараа, тавилгынх 8.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрных 6.8 хувь, согтууруулах ундаа, тамхиных 5.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 3.4 хувь, холбооны үйлчилгээнийх 0.5 хувиар өсчээ.(Зураг II.4).

Улаанбаатар хотод 2011 оны эцэст өмнөх оныхоос хэрэглээний сагсны 287 нэрийн бараа, үйлчилгээний 73.5 хувийнх нь үнэ өсч, 8.7 хувийнх нь үнэ буурч, 17.8 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 72 нэрийн барааны 75.0 хувь буюу 54 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Хэрэглээний үнийн ерөнхий индекс 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.3 хувиар нэмэгдэхэд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 3.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн гэр ахуйн тавилга, барааных 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.1 хувь, тээврийн бүлгийнх 0.3 хувь, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээнийх 0.7 хувиар өссөн байна. Харин хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.3 хувиар буурч, эдгээрээс бусад бүлгийн үнэ тогтвортой байв.

Зураг-II.6





Улаанбаатар хотын хэрэглээний үнийн жилийн индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт, %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	8,9	Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 19.9 хувь, жимс, жимсгэнийх 29.3 хувь, төмс, хүнсний ногооных 1.8 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүнийх 5.4 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүний үнэ 11.4 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	5,8	Энэ бүлгийн үнийн өсөлт нь импортын архи, шар айрагны үнэ 10.7-34.9 хувь, импортын тамхины үнэ 13.4 хувиар нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
Хувцас, бөс бараа, гутал	17,5	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөд хөвөн бөс барааны үнэ 12.8 хувь, эрэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 15.0 хувь, эмэгтэй хувцасных 13.5 хувь, хүүхдийнх 24.2 хувь, бүх төрлийн гутлынх 20.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	11,6	Энэ бүлгийн үнийн өсөлт нь орон сууцны бодит түрээсийн үнэ 22.5 хувь, орон сууцны засварын материалын үнэ 14.2 хувь, засвар хийх хөлс 25.0 хувь, 1м2 талбайн халаалтын хөлс 12.2 хувь, айл өрхийн 1квт цахилгааны төлбөр 5.3-5.6 хувь, 1 шуудай нүүрсний үнэ 23.3 хувь, түлшний модны үнэ 36.4 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	8,1	Гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнийн өсөлтөд гэрийн тавилга хэрэгслийн үнэ 14.4 хувь, оёмол, нэхмэл эдлэлийнх 9.9 хувь, цахилгаан барааных 4.3 хувь, шилэн эдлэл, сав суулганых 25.4 хувь, гэр ахуйн багаж хэрэгслийнх 11.3 хувь, цэвэрлэгээний бодисын үнэ 5.5 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3,4	Энэ бүлгийн үнийн өсөлт нь эм, тарианы үнэ 3.7 хувь, шүдэнд ломбо тавиулах хөлс 6.3 хувь, эмнэлгийн ор хоногийн хөлс 2.6 хувиар нэмэгдсэнтэй холбоотой.
Тээвэр	21,9	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд судалгаанд сонгогдсон унадаг дугуйны үнэ 69.2 хувь, автобензин, дизелийн түлшний үнэ 12.9-25.0 хувь, автобусны билетийн үнэ 33.3 хувь, микроавтобусных 25.0 хувь, таксины хөлс 20.0 хувиар өссөн нь нөлөөллөө.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0,5	Энэ бүлгийн үнийн өсөлт нь шуудан, илгээмжийн үйлчилгээний үнэ 18.8 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	8,7	Энэ бүлгийн үнийн өсөлтөд компьютерийн үнэ 41.3 хувь, гэрэл зургийн хальсны үнэ 6.6 хувь, зөөлөн тоглоомын үнэ 17.1 хувь, кино театрын үзвэрийн үнэ 17.5 хувь, зураг буулгах хөлс 4.0 хувь, сурагчийн дэвтрийн үнэ 6.1 хувь, дугуйных 66.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.
Боловсролын үйлчилгээ	10,2	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.2 хувиар өссөн нь улсын их, дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 12.1 хувь, хувийн сургуулийнх 8.0 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	6,8	Энэ бүлгийн үнийн өсөлтөд нийтийн хоолны үнэ 6.6 хувь, оюутны дотуур байрны төлбөр 10.0 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.
Бусад бараа, үйлчилгээ	13,8	Энэ бүлгийн үнийн өсөлт нь үс засах хөлс 19.9-40.0 хувь, нүүрэнд иллэг хийх хөлс 72.2 хувь, ариун цэврийн барааны үнэ 13.6 хувь, бугуйн цагны үнэ 17.7 хувь, алтан бөгжний үнэ 17.2 хувиар өссөнөөс шалтгаалжээ.



Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2011 оны 12 дугаар сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Өмнөговь, Баян-Өлгий, Увс, Өвөрхангай, Ховд аймагт хамгийн бага буюу 20.0-26.0 мян. төг, Архангай, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 38.0-40.0 мян.төг, адууны ширнийх Орхон аймагт хамгийн бага буюу 25.0 мян.төг, Баян-Өлгий, Дундговь, Хэнтий аймагт хамгийн их буюу 41.0-43.0 мян.төг, ямааны цагаан ноолуурын үнэ Өмнөговь аймагт хамгийн бага буюу 40.0 мян.төг, Орхон, Дундговь, Ховд аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 49.0-50.0 мян.төг байна.


Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Увс, Завхан, Ховд аймагт өмнөх

сарынхаас 3.0-5.0 мян.төг буюу 13.6-18.2 хувиар өсч, харин Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Сэлэнгэ, Булган, Төв аймагт өмнөх сарын түвшинд байв.


Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод, Булган, Ховд аймагт өмнөх сарынхаас 7.0-16.0 мян. төг буюу 21.9-72.7 хувиар өсч, Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Өвөрхангай аймагт өмнөх сарын түвшинд байв.

Ямааны цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ Баян-Өлгий, Дундговь, Дорноговь аймагт өмнөх сарынхаас 3.0-5.0 мян.төг буюу 6.7-12.5 хувиар өсч, харин Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Архангай, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотод 1.5-10.0 мян.төг буюу 3.0-20.0 хувиар буурчээ.

Зураг-II.7



Зураг-II.8





Улаанбаатар хотод арилжаалагдсан барилгын гол нэрийн материалын 2011 оны 12 дугаар сарын дундаж үнэ

Улаанбаатар хотод 2011 оны 12 дугаар сард арилжаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 37 нэр төрлийн материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа.

Өмнөх оны мөн үеийнхээс эх орны үйлдвэрийн хөнгөн бетоны үнэ 2011 оны 12 дугаар сард 19.5 мян.төг буюу 20.4 хувь, хуурай палкных 3.0 мян.төг буюу 15.0 хувь, 50 кг-ын савлагаатай цементнийх 0.7 мян.төг буюу 12.1 хувь, шалны банзных (ховилгүй) 2.0 мян.төг буюу 1.4 хувь, ОХУ-д үйлдвэрлэсэн хар цаасны үнэ (чулуутай) 5.5 мян.төг буюу 37.9 хувиар өсчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн хар цаасны (чулуугүй) үнэ 2.0 мян.төг буюу 28.6 хувь, цонхны шилнийх (нөлөөгүй) 3.0

мян.төг буюу 25.0 хувь, 50 кг-ын савлагаатай цементнийх 1.5 мян.төг буюу 23.1 хувь, уян шүршүүрнийх 3.0 мян.төг буюу 20.0 хувь, шахмал шалных 2.0 мян.төг буюу 20.0 хувь, шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 12.5 хувь, крантных 5.0 мян.төг буюу 12.5 хувь, өдрийн гэрлийнх (суурьгүй) 0.2 мян.төг буюу 11.1 хувь, шаазан угаагуурынх 5.0 мян.төг буюу 9.1 хувь, ханын цаасных 0.5 мян.төг буюу 6.3 хувь, төмөр хаалганых 3.0 мян.төг буюу 2.2 хувиар өсч, харин тараган цавуу болон дүүжин таазны үнэ тус бүр 0.5 мян.төг буюу 12.5 хувиар буурчээ. БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 1.0 мян.төг буюу 22.2 хувиар өсөв.

Өмнөх сарынхаас эх орны үйлдвэрийн хуурай палкны үнэ 2.0 мян.төг буюу 8.0 хувь, захалсан банзных 3.0 мян.төг буюу 7.9 хувь, шалны банзных (ховилгүй) 8.0 мян.төг буюу 5.3 хувиар буурч, БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаас 0.5 мян.төг буюу 10.0 хувиар өссөн байна. Бусад материалын үнэ тогтвортой байлаа.


II. Мөнгө, зээл, үнэт цаас

Хүснэгт-II.2

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2011 оны эцэст 6427.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 304.0 тэрбум төг буюу 5.0 хувь, өмнөх оныхоос 1747.2 тэрбум төг буюу 37.3 хувиар өсчээ (Хүснэгт II.2). Мөнгөний нийлүүлэлт 2011 оны эхнээс 1621.7 тэрбум төг буюу 33.7 хувиар өсөхөд бараг мөнгө 1012.2 тэрбум төг буюу 27.5 хувь, бага мөнгө (M1) 609.6 тэрбум төг буюу 53.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна (Зураг II.9).

Зураг-II.9

Мөнгөний нийлүүлэлт (M2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)



Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2009 XII	2010 XII	2011 XI	2011 XII
Мөнгөний нийлүүлэлт M2	2 880,0	4 680,0	6 123,2	6 427,2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	26,9	62,5	55,4	37,3
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	6,1	18,8	0,6	5,0
Нийт хадгаламж	1 856,4	2 756,2	3 824,5	3 905,2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	38,7	48,5	60,6	41,7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	7,6	15,8	1,9	2,1
Төгрөгийн хадгаламж	1 234,3	2 001,6	2 819,6	2 922,4
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	37,3	62,2	61,2	46,0
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	7,6	14,4	- 1,2	3,6
Валютын хадгаламж	622,1	754,6	1 004,9	982,8
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	41,3	21,3	59,1	30,2
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	7,6	19,5	11,5	- 2,2

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2011 оны эцэст 45.5 хувийг төгрөгийн хадгаламж, 15.3 хувийг гадаад валютын хадгаламж, 19.0 хувийг төгрөгийн харилцах, 12.1 хувийг гадаад валютын харилцах, 8.1 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж



байна (Зураг II.10). Мөнгөний нийлүүлэлтэд төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь өмнөх оныхоос 2.7 пункт, төгрөгийн харилцахынх 2.6 пунктээр өсч, харин гадаад валютын харилцахынх 4.3 пункт, гадаад валютын хадгаламжийнх 0.8 пункт, банкнаас гадуурх мөнгөнийх 0.2 пунктээр буурчээ.

Бага мөнгө 2011 оны эцэст 1741.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 188.5 тэрбум төг буюу 12.1 хувиар өслөө. Бага мөнгө өмнөх оныхоос 583.5 тэрбум төг буюу 50.4 хувиар нэмэгдэхэд төгрөгийн харилцах 454.2 тэрбум төг буюу 59.0 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2011 оны эцэст 3905.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 80.7 тэрбум төг буюу 2.1 хувь, өмнөх оныхоос 1149.0 тэрбум төг буюу 41.7 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2011 оны эцэст 2922.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 102.8 тэрбум төг буюу 3.6 хувь, өмнөх оныхоос 920.8 тэрбум төг буюу 46.0 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2011 оны эцэст 982.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 22.1 тэрбум төг буюу 2.2 хувиар буурч, өмнөх оныхоос 228.2 тэрбум төг буюу 30.2 хувиар нэмэгджээ (Хүснэгт II.1).

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2011 оны эцэст 713.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 34.4 тэрбум төг буюу 5.1 хувь, өмнөх оныхоос 193.7 тэрбум төг буюу 37.3 хувиар өсчээ.

Нөөц мөнгө (M0) 2011 оны эцэст 1659.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 143.2 тэрбум төг буюу 9.4 хувиар өслөө. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2011 оны эцэст өмнөх сарынхаас 108.7 тэрбум төг буюу 12.9 хувиар өсч, 948.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2011 оны эцэст 8652.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 748.8 тэрбум төг буюу 9.5 хувь, өмнөх оныхоос 2779.1 тэрбум төг буюу 47.3 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны эцэст 5641.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 202.4 тэрбум төг буюу 3.7 хувь, өмнөх оныхоос 2376.4 тэрбум төг буюу 72.8 хувиар өсчээ. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл оны эхнээс 2200.9 тэрбум төг буюу 64.0 хувиар өсөхөд хэвийн зээл 2261.6 тэрбум төг буюу 76.0 хувиар нэмэгдэж чанаргүй зээл 31.5 тэрбум төг буюу 8.7 хувиар буурсан нь голлон нөлөөлөв (Хүснэгт II.3).


Зураг-II.10

Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар



Зураг-II.11

Мөнгөний нийлүүлэлт (M2), бага мөнгө (M1) болон бараг мөнгөний өөрчлөлт сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)



Хүснэгт-II.3

Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2010 XII	2011 XI	2011 XII
Зээлийн өрийн үлдэгдэл	3 264,8	5 438,7	5 641,1
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	23,0	74,7	72,8
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	4,9	4,2	3,7
Чанаргүй зээл	374,4	343,2	330,0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 19,0	- 7,5	- 11,9
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	0,9	- 1,3	- 3,8
Хугацаа хэтэрсэн зээл	90,6	71,5	73,7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 25,6	- 20,8	- 18,7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	0,4	17,4	3,1
Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь	11,5	6,3	5,8
Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	2,8	1,3	1,3



Зээлийн өрийн үлдэгдлийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2011 оны эцэст нийт зээлийн 3104.5 тэрбум төг буюу 55.0 хувь нь хувийн секторт, иргэдийнх 2452.6 тэрбум төг буюу 43.5 хувь, улсын байгууллагынх 60.6 тэрбум төг буюу 1.1 хувь, бусад санхүүгийн байгууллагынх 17.5 тэрбум төг буюу 0.3 хувь, бусад байгууллагынх 5.9 тэрбум төг буюу 0.1 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2011 оны эцэст 330.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 13.2 тэрбум төг буюу 3.8 хувь, өмнөх оныхоос 44.4 тэрбум төг буюу 11.9 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.5 пункт, өмнөх оныхоос 5.7 пунктээр буурчээ (Хүснэгт II.3).

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны эцэст 73.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 2.2 тэрбум төг буюу 3.1 хувиар өсч, өмнөх оныхоос 16.9 тэрбум төг буюу 18.7 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.5 пунктээр буурсан байна (Хүснэгт II.2).

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 67.0 хувь нь ХААН банк, Голомт банк, Худалдаа, хөгжлийн банканд 2011 оны эцэст ногдож байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2011 оны 11 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 0.2 пунктээр өсч, өмнөх оны мөн үеийнхээс 2.8 пунктээр буурч, жилийн хүү 16.1 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 1.1 пунктээр, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 пунктээр буурч, жилийн хүү 12.2 хувь боллоо (Зураг II.13).


Гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны эцэст өмнөх сарынхаас 17.8 сая ам.доллараар буурч, өмнөх оныхоос 182.8 сая ам.доллараар нэмэгдэж, 2273.9 сая ам.долл болж, манай улсын импортын 18.2 долоо хоног буюу 4.6 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.14).

Үнэт цаасны зах зээл

Монголын хөрөнгийн биржид 2011 оны эцэст 332 компани бүртгэлтэй байгаагаас 52 нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани, 280 нь хувийн өмчийн компани байна.


Зураг-II.12

Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг




Зураг-II.13

Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар



Зураг-II.14

Гадаад валютын цэвэр албан нөөц, сарын эцэст, сая ам.долл





Үнэт цаасны арилжааг 2011 онд нийт 252 өдөр явуулж, 350.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 125.6 сая ш үнэт цаас арилжсан байна.

ТОП-20 дундаж индекс 2010 онд 10582.8 байсан бол 2011 онд 21421.8 болж өсчээ. Өдөрт дунджаар 2011 онд 498.4 мянган хувьцаа арилжаалагдаж, 1389.8 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ. Ремикон, Женко тур бюро, Гермес центр, Хай би ойл, Хөх ган зэрэг хувьцаат компанийн хувьцаа хамгийн идэвхтэй арилжаалагдсан байна. Харин Сүү, Баянтээг, Таван толгой, Баянгол зочид буудал, Сөдөт зэрэг хувьцаат компаниуд зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компанийн тоонд орж байна.

Үнэт цаасны арилжаа 2011 оны 12 дугаар сард 21 өдөр явагдаж, 9.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 5.6 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 25.0 тэрбум төг буюу 73.5 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1.0 тэрбум төг буюу 12.7 хувиар өсчээ. Арилжсан үнэт цаасны тоо өмнөх сарынхаас 4560.4 сая ш буюу 45.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 526.9 мян ш буюу 10.5 хувиар өслөө.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2011 оны 12 дугаар сард 19846.7 болж, өмнөх сарынхаас 1302.0 нэгжээр буурчээ (Зураг II.15). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2011 оны 12 дугаар сард 2168.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 12.8 тэрбум төг буюу 0.6 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 794.6 тэрбум төг буюу 57.8 хувиар өслөө (Зураг II.16).


“РЕМИКОН” хувьцаат компанийн 2.0 сая ш хувьцаа 2011 оны 12 дугаар сард арилжигдсан нь хамгийн идэвхтэй арилжаалсан үнэт цаас байв.

Валютын ханш

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард 1374.2 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 140.1 төг буюу 11.4 хувиар суларсан байна (Хүснэгт II.4). Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 2.4 хувь, 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 3.8 хувиар суларчээ (Зураг II.17).


Зураг-II.15

ТОП-20 индекс, сарын дундаж, хувиар



Зураг-II.16

Зах зээлийн үнэлгээ, сарын эцэст, тэрбум төг




Хүснэгт-II.4

Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Үзүүлэлт	2010 XII	2011 XI	2011 XII
Ам. Доллар	1 234,1	1 323,4	1 374,2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 14,7	1,5	11,4
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 5,4	2,4	3,8
Евро	1 631,3	1 793,8	1 811,6
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 22,9	2,5	11,1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 6,8	1,3	1,0
Юань	185,6	208,2	216,5
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 12,4	8,8	16,6
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 3,0	2,7	4,0
Рубль	40,0	42,9	43,7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 17,2	4,1	9,3
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 2,8	3,9	1,9

Зураг-II.17

Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг





Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард 1811.6 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 180.3 төг буюу 11.1 хувиар суларчээ (Хүснэгт II.3). Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.3 хувиар, 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.0 хувиар суларсан байна (Зураг II.18).

Зураг-II.18



Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард 216.5 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 30.9 төг буюу 16.6 хувиар суларчээ (Хүснэгт II.4). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 2.7 хувь, 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 4.0 хувиар суларчээ (Зураг II.19).

Зураг-II.19



Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард 43.7 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.7 төг буюу 9.3 хувь суларчээ (Хүснэгт II.4). Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 3.9 хувиар, 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.9 хувиар суларлаа (Зураг II.20).


Зураг-II.20



II.4 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4400.6 тэрбум төг, үүнээс тогтворжуулалтын сангийн орлого 241.0 тэрбум төг болж, нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн хэмжээ 4159.6 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4792.0 тэрбум төгрөгт хүрч, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 632.4* тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өмнөх онд улсын нэгдсэн төсөв 41.8 тэрбум төгрөгийн ашигтай гарч байв (Зураг II.21).

Зураг-II.21



Төсвийн урсгал орлого 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4141.3 тэрбум төг, урсгал зардал 3234.4 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 906.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Өмнөх оныхоос урсгал орлого 1063.0 тэрбум төг буюу 34.5 хувь, урсгал зардал 978.1 тэрбум төг буюу 43.4 хувиар өсөв.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2011 оны 1, 4, 5, 9, 10, 11, 12 дугаар саруудад 1.0-540.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин бусад сард 9.4-101.6

* Төсвийн тэнцвэржүүлсэн орлого

** Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл



тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 2011 оны 1 дүгээр сард 9.2 тэрбум төг, 12 дугаар сард 21.7 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин бусад сард 18.4-217.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа (Зураг II.22).

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны 12 дугаар сард 540.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 154.5 тэрбум төг буюу 40.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 61.2 тэрбум төг буюу 12.8 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2011 оны 12 дугаар сард 978.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 450.0 тэрбум төг буюу 85.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 470.2 тэрбум төг буюу 92.5 хувиар өсчээ.

Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсөвт 2011 урьдчилсан гүйцэтгэлээр 4400.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оныхоос 1278.2 тэрбум төг буюу 40.9 хувиар өссөн байна.


Татварын нийт орлого өмнөх оныхоос 948.6 тэрбум төг буюу 35.3 хувиар нэмэгдэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 367.3 тэрбум төг буюу 86.8 хувиар буурсан хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 563.2 тэрбум төг буюу 65.1 хувь, бусад татварын орлого 262.2 тэрбум төг буюу 84.7 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 154.4 тэрбум төг буюу 39.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 144.1 тэрбум төг буюу 74.5 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 119.1 тэрбум төг буюу 36.0 хувь, хүн амын орлогын албан татварын орлого 69.7 тэрбум төг буюу 43.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оныхоос 114.4 тэрбум төг буюу 29.3 хувиар нэмэгдэхэд хувьцааны ногдол ашгийн орлого 33.4 тэрбум төг буюу 60.5 хувь, төсөвт газрын өөрийн орлого 22.1 тэрбум төг буюу 13.5 хувь, хүү, торгуулийн орлого 21.4 тэрбум төг буюу 59.2 хувь, газрын тосны орлого 21.2 тэрбум төг буюу 38.7 хувь, бусад нэр заагдаагүй орлого 12.8 тэрбум төг буюу 26.8 хувь, навигацын орлого 3.5 тэрбум төг буюу 11.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 82.6 хувийг

Зураг-II.22

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт болон урсгал тэнцэл, сараар, тэрбум төг



татварын орлого, 11.5 хувийг татварын бус орлого, 5.5 хувийг тогтворжуулалтын сангийн орлого, 0.4 хувийг хөрөнгийн орлого, эзэлж байгаа нь өмнөх оныхоос татварын орлогынх 3.4 пункт, тусламжийн орлогынх 1.2 пункт, татварын бус орлогынх 1.0 пунктээр буурч, хөрөнгийн орлогынх 0.2 пунктээр өсчээ (Хавсралт 5).

Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4792.0 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1711.3 тэрбум төг буюу 55.6 хувиар нэмэгдсэн нь зээлийн үйлчилгээний төлбөр 5.0 тэрбум төг буюу 11.8 хувиар буурсан хэдий ч татаас, шилжүүлгийн зардал 621.4 тэрбум төг буюу 59.3 хувь, хөрөнгийн зардал 476.1 тэрбум төг буюу 80.6 хувь, бараа, үйлчилгээний зардал 361.8 тэрбум төг буюу 31.0 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 257.1 тэрбум төг буюу 2.1 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 67.5 хувь, хөрөнгийн зардал 22.3 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 10.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос урсгал зардлын эзлэх хувь 5.7 пунктээр буурч, хөрөнгийн зардлынх 3.1 пункт, эргэж төлөгдөх цэвэр зээлийнх хувь 2.7 пунктээр өсчээ (Хавсралт 5).



Хөрөнгийн зардал

Хөрөнгийн зардалд 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1067.2 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оныхоос 476.1 тэрбум төг буюу 80.6 хувиар нэмэгджээ. Энэ нь дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 454.1

тэрбум төг буюу 80.9 хувь, гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 22.0 тэрбум төг буюу 74.9 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлбар: “Төсвийн тогтвортой байдлын тухай” Монгол улсын хуулийн дагуу тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг тооцож гаргав.

II.5 Гадаад худалдаа

Монгол Улс 2011 онд урьдчилсан байдлаар дэлхийн 127 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 11307.2 сая ам.долл, үүнээс экспорт 4780.4 сая ам.долл, импорт 6526.9 сая ам.долларт хүрчээ (Зураг II.23). Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 5198.7 сая ам.долл, үүнээс импортын хэмжээ 3326.8 сая ам.долл, экспортын хэмжээ 1871.8 сая ам.доллараар өсчээ.


Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2010 онд 2009 оныхоос 51.8 хувь, экспорт 54.3 хувь, импорт 49.7 хувь, 2011 онд нийт бараа эргэлт 2010 оныхоос 85.1 хувь, экспорт 64.4 хувь, импорт 2.0 дахин өсчээ.

2009 онд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 48.0 хувь нь БНХАУ-д, 20.9 хувь нь ОХУ-д, үлдсэн 31.1 хувь нь бусад улсад, 2010 онд нийт бараа эргэлтийн 56.3 хувь нь БНХАУ-д, 18.5 хувь нь ОХУ-д, үлдсэн 25.2 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2011 онд урьдчилсан байдлаар нийт бараа эргэлтийн 56.7 хувь нь БНХАУ-д, 15.0 хувь нь ОХУ-д, 28.3 хувь нь бусад улсад ногдож байна. ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 2011 онд өмнөх оныхоос 3.5 пунктээр буурч, БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 0.4 пункт, бусад улсынх 3.1 пунктээр өсчээ.


Гадаад худалдааны нийт бараа эргэлтийг сараар авч үзэхэд 2009 онд 12 дугаар сард хамгийн их буюу 460.0 сая ам.долл, 2010 онд мөн 12 дугаар сард 686.8 сая ам.долларт хүрч байсан бол 2011 онд 8 дугаар сард хамгийн их буюу 1254.8 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 онд 291.6 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 39.3 сая ам.долл буюу 15.6 хувиар нэмэгдэж байсан бол 2011 онд урьдчилсан байдлаар 1746.5 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 1455.0 сая ам.долл буюу 6.0 дахин өсчээ. Үүнд импортын өсөлт экспортынхоос 39.6 пунктээр өндөр байгаа нь нөлөөлөв.

Зураг-II.23



Зураг-II.24



Гадаад худалдааны тэнцэл 2009 оны 12 дугаар сард 8.9 сая ам.долл, 2010 оны 12 дугаар сард 28.9 сая ам.долларын ашигтай гарч байсан бол 2011 оны 12 дугаар сард урьдчилсан байдлаар 41.8 сая ам.долларын алдагдалтай гарчээ.

Экспорт

Монгол Улс 2011 онд урьдчилсан байдлаар нийт 65 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 92.1 хувь, ОХУ-д 2.0 хувь, Канад улсад 1.9 хувь, Итали улсад 1.1 хувь, БНСУ-д 0.8 хувь, Швейцарь болон Их Британи улсад тус бүр 0.4 хувь, ХБНГУ-д 0.3 хувь, Япон улсад 0.2 хувь ногдож байгаа нь нийт экспортын 99.2 хувийг эзэлж байна (Зураг II.24).

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2009 онд нийт экспортод 66.4 хувь, 2010 онд 81.0 хувь,



2011 оны урьдчилсан байдлаар 89.2 хувийг эзэлж байна.

Зураг-II.25

Экспортын 98.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.25).

Экспортын хэмжээ 1871.8 сая ам.доллараар нэмэгдэхэд үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт өмнөх оныхоос 65.2 сая ам.долл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийх 29.8 сая ам.доллараар буурсан хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 1909.7 сая ам.долл, нэхмэл бүтээгдэхүүнийх 25.0 сая ам.долл, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэлийнх 17.8 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Экспортод нүүрс 47.1 хувь, зэсийн баяжмал 20.2 хувь, төмрийн хүдэр 9.1 хувь, боловсруулаагүй газрын тос 5.3 хувь, цайрын хүдэр, баяжмал 3.0 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 2.4 хувь, жоншны хүдэр, баяжмал 2.0 хувь, самнасан ноолуур 1.2 хувь, бусад бүтээгдэхүүн 9.7 хувийг эзэлж байна.

Нийт экспортод эзлэх хувь өмнөх оныхоос зэсийн баяжмалынх 6.3, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 3.7, цайрын хүдэр, баяжмалынх 1.6, самнасан ноолуурынх 1.2, жоншны хүдэр, баяжмалынх 0.4 пунктээр буурч, харин нүүрснийх 16.8, төмрийн хүдрийнх 0.4 пунктээр нэмэгджээ.


Нүүрсний экспорт 2009 онд 7.1 сая т, нийт экспортод 16.2 хувь, 2010 онд 16.7 сая т, нийт экспортод 30.3 хувь, 2011 онд 21.1 сая т, нийт экспортод 47.1 хувийг эзэлж байна.

Импорт

Монгол Улс 2011 онд урьдчилсан байдлаар нийт 124 оронтой импортын худалдаа хийсний 30.8 хувийг БНХАУ-тай, 24.5 хувийг ОХУ-тай, 8.2 хувийг АНУ-тай, 7.4 хувийг Япон улстай, 5.4 хувийг БНСУ-тай, 4.2 хувийг ХБНГУ-тай, 2.3 хувийг Украин улстай, 2.0 хувийг Канад улстай хийсэн нь нийт импортын 84.8 хувийг эзэлж байна (Зураг II.26).


Нийт импортод ОХУ-ын эзлэх хувь өмнөх оныхоос 8.2, БНСУ-ынх 0.3 пунктээр буурч,

Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2011 оны эцсийн байдлаар



Зураг-II.26

Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар



Хүснэгт-II.5

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эцсийн байдлаар, мян.т

	2009	2010	2011*
Нүүрс	7 113,2	16 726,2	21 105,6
Зэсийн баяжмал	587,0	568,7	572,8
Боловсруулаагүй газрын тос	1 938,5	2 070,8	2 540,5
Цайрын баяжмал	150,7	119,8	120,7
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	10,9	5,1	2,7

харин АНУ-ынх 3.2, ХБНГУ-ынх 1.5, Япон болон Канад улсынх тус бүр 1.3, Украин улсынх 1.0, БНХАУ-ынх 0.5 пунктээр өсчээ.

Өмнөх оныхоос импортын хэмжээ 3326.8 сая ам.доллараар нэмэгдэхэд машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 1090.8 сая ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийн импорт 888.9 сая ам.долл, эрдэс бүтээгдэхүүний импорт 498.2 сая ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 383.7 сая ам.долл, хуванцар,



каучук, түүгээр хийсэн эдлэлийнх 119.0 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 89.2 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв. Харин ургамлын гаралтай бүтээгдэхүүнийх 19.0 сая ам.доллараар буурлаа.

Нийт импортын 27.2 хувийг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг, 22.9 хувийг авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 19.2 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 9.0 хувийг үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн, 5.0 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 3.9 хувийг хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 3.5 хувийг хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл, үлдсэн 9.3 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.27).

Импортолсон цахилгаан эрчим хүчний биет хэмжээ өмнөх оныхоос 24.8 сая квт. цагаар буурч, харин үнийн дүн 2.0 сая ам.долл, автобензиний биет хэмжээ 37.8 мян.т, үнийн дүн 117.7 сая ам.долл, суудлын автомашины биет хэмжээ 29.7 мян.ш, үнийн дүн 273.6 сая ам.долл, гурилын биет хэмжээ 2.0 т, үнийн дүн 8.3 сая ам.доллараар өсчээ (Зураг II.29).


Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2011 онд урьдчилсан байдлаар 1011.1 мян.т буюу 1134.9 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 17.4 хувийг эзэлж байна. Газрын тосны бүтээгдэхүүний импорт өмнөх оныхоос 184.8 мян.т буюу 22.4 хувиар нэмэгдэв.

Газрын тосны бүтээгдэхүүнийг 2011 онд урьдчилсан байдлаар ОХУ, БНХАУ, БНСУ-аас, гурилыг ОХУ болон Казахстан улсаас, цагаан будааг БНХАУ, Вьетнам, ОХУ-аас, элсэн чихрийг Тайланд, Бразил, Колумба, Малайз улсаас, нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, ОХУ-аас, суудлын автомашиныг Япон, БНСУ, ХБНГУ, Их Британи улс, АНУ-аас, ачааны автомашиныг БНХАУ, АНУ, БНСУ, Беларусь, Энэтхэг улсаас голлон нийлүүлсэн байна.

Импортолсон барааны 79.3 хувийг валютын төлбөртэй худалдаа, 18.3 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 2.2 хувийг тусламжийн бараа, 0.2 хувийг бусад төрлийн худалдаа эзэлж байна. Өмнөх оныхоос валютын төлбөртэй худалдааных 11.1, гадаадын тусламжийн барааных 1.8, бараа солилцооных 0.1 пунктээр буурч, харин хөрөнгө оруулалтын барааных 13.4 пунктээр өсчээ.


Зураг-II.27

Импортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2011 оны эцсийн байдлаар



Зураг-II.28


Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар



- Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг
- Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги
- Эрдэс бүтээгдэхүүн
- Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн
- Бусад

Зураг-II.29

Зарим барааны импорт, жил бүрийн эцсийн байдлаар, мян.ам.долл





Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Дундговь аймаг; хонин сүргийн тоогоор Архангай, Төв, Хөвсгөл, Булган, Хэнтий аймаг; ямаан сүргийн тоогоор Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Төв, Говь-Алтай аймаг эхний таван байранд орсон байна.

Улсын хэмжээгээр 2011 оны эцэст малтай 211.7 мян.өрх байгаагийн 154.9 мян.өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Малчин нэг өрх 2011 онд дунджаар 4 ам бүлтэй байна (Хавсралт 13).

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй малчдын тоо 2011 оны эцэст 311.2 мянга болж, 16-34 насны малчид 41.4 хувь, 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчид 46.0 хувь, тэтгэврийн насны малчид 12.6 хувийг эзэлж байна (Хавсралт 14).

Малтай нийт өрхийн тоо өмнөх оныхоос 2.2 хувиар, үүнээс 500 хүртэлх малтай өрхийн тоо 3.5 хувиар буурсан ч 500-аас дээш малтай өрхийн тоо 20.6 хувиар өссөн байна.

Улсын хэмжээгээр 2011 онд малтай нэг өрхөд ногдох малын тоо дунджаар 170 болж, өмнөх оныхоос 13.3 хувиар өслөө. Малтай нэг өрхөд 10 адуу, 11 үхэр, 1 тэмээ, 73 хонь, 75 ямаа ногдож байна. Өмнөх оныхоос малтай нэг өрхөд ногдох адуу, үхэр тус бүр 1, хонь 7, ямаа 11-оор өсч, харин тэмээний тоо өөрчлөгдөөгүй байна (Хавсралт 18).

Малтай өрхийн 48.4 хувь нь 100 хүртэл, 23.4 хувь нь 101-200, 21.6 хувь нь 201-500, 5.3 хувь нь 501-999, 1.3 хувь нь 1000-аас дээш тооны малтай байна.


Малтай нэг өрхөд ногдох малын тоо Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Дундговь, Төв, Сүхбаатар, Говьсүмбэр, Булган, Дорноговь, Хэнтий аймагт улсын дунджаас 3-84 толгойгоор илүү, бусад аймагт 1-98 толгойгоор бага байна.

Малчин өрхөд ногдох малын тоо 2011 оны эцэст 235 болж, өмнөх оныхоос 15.2 хувиар өслөө (Зураг III.6). Нийт малчин өрхийн 41.1 хувь нь Хангайн, 26.8 хувь нь Баруун, 19.6 хувь нь Төвийн, 11.2 хувь нь Зүүн бүсэд, 1.3 хувь нь Улаанбаатарт тус тус ногдож байна.

Цахилгаан эрчим хүчний үүсгүүртэй малчин өрхийн тоо 2011 онд 136.0 мянгад хүрч, өмнөх оныхоос 2.4 мян буюу 1.8 хувиар нэмэгдсэн байна. Эдгээр өрхийн 121.8 мян буюу 89.6 хувь нь нарны цахилгаан үүсгүүртэй байна (Зураг III.7).


Зураг-III.4

Малтай өрхийн тоо, малын тооны бүлэглэлтээр




Зураг-III.5

Малчин өрхийн тоо




Зураг-III.6

Нэг малчин болон малтай өрхөд ногдох малын тоо



Зураг-III.7

Малчин өрхийн цахилгаан үүсгүүр, төрлөөр, 2011 оны байдлаар, хувиар





Малчин өрхийн 87.8 хувь нь цахилгаан эрчим хүчний үүсгүүртэй, 80.7 хувь нь телевизортой, 31.3 хувь нь авто машинтай, 48.3 хувь нь мотоциклтой, 1.8 хувь нь трактортой, 78.1 хувь нь малын хашаатай, 21.4 хувь нь худагтай байна.

Өмнөх оныхоос нийт малчин өрхөд цахилгаан эрчим хүчний үүсгүүртэй өрхийн эзлэх хувь 4.4 пункт, телевизортой өрхийн эзлэх хувь 4.9 пункт, авто машинтай өрхийн эзлэх хувь 3.5 пункт, мотоциклтой өрхийн эзлэх хувь 6.6 пунктээр өслөө (Зураг III.8), (Хавсралт 15, 16).

Улсын хэмжээнд 2011 оны байдлаар оны эхний эх малын 84.6 хувь буюу 13.1 сая эх мал төллөжээ (Хавсралт 23). Гүүний 76.4 хувь, үнээний 76.5 хувь, ингэний 48.7 хувь, эм хонины 86.8 хувь, эм ямааны 84.6 хувь нь төллөв. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 3.1 пунктээр өссөнөөс гүүнийх 24.2, үнээнийх 14.8, ингэнийх 3.1, эм хониных 22.2, эм ямааных 35.2 пунктээр дээгүүр байна.

2011 онд нийт гарсан төлийн 12.5 сая буюу 94.9 хувийг нь бойжуулсан нь өмнөх оныхоос 5.1 сая толгойгоор, төл бойжилтын хувь 26.9 пунктээр дээгүүр байна (Хавсралт 24). Унаганы 94.7 хувь, тугалны 96.0 хувь, ботгоны 95.8 хувь, хурганы 95.1 хувь, ишигний 94.5 хувь нь бойжиж, төл бойжилтын хувь бүх төрлөөр өмнөх оныхоос 6.8-32.0 пунктээр өслөө.


Оны эхэнд тоологдсон нийт малын 2.0 хувь буюу 0.7 сая том мал 2011 онд зүй бусаар хорогдов. (Зураг III.11, Хавсралт 25).

Нийт хорогдсон малын 56.6 мян буюу 8.7 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Оны эхний малд хорогдлын эзлэх хувь Баруун бүсэд хамгийн их буюу 2.7 хувь, Хангайн бүсэд 2.4 хувь, Зүүн бүсэд 1.9 хувь, Төвийн бүсэд 0.7 хувь, Улаанбаатар хотод 1.0 хувь байна.

Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2011 онд 53 болж, өмнөх оныхоос 10.4 хувиар өслөө. Энэ үзүүлэлт Орхон аймагт 796, Улаанбаатар хотод 274, Дархан-Уул аймагт 257, Булган аймагт 165, Архангай аймагт 155, Сэлэнгэ 135, Хөвсгөл аймагт 128 толгой байгаа нь улсын дунджаас нилээд өндөр байна.


Зураг-III.8

Малчин өрхийн нийгэм, ахуйн зарим үзүүлэлтүүд




Зураг-III.9

Бойжсон төл




Зураг-III.10

Хорогдсон том мал



Зураг-III.11

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох малын тоо





III.3 Газар тариалан

Улсын хэмжээгээр 2011 оны байдлаар нийт 345.9 мян.га талбайд тариалалт хийснээс 299.9 мян.га-д үр тариа, 15.4 мян.га-д төмс, 7.8 мян.га-д хүнсний ногоо, 10.9 мян.га-д тэжээлийн ургамал, 11.9 мян.га-д техникийн ургамал, жимс, жимсгэнэ тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 30.6 мян.га-гаар буюу 9.7 хувь өссөн байна.

2011 онд 446.1 мян.т үр тариа, 201.6 мян.т төмс, 99.0 мян.т хүнсний ногоо хурааж, 1195.2 мян.т хадлан, 46.7 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос хураасан үр тариа 91.0 мян.т буюу 25.6 хувь, төмс 33.7 мян.т буюу 20.1 хувь, хүнсний ногоо 16.7 мян.т буюу 20.3 хувь, хадлан 58.0 мян.т буюу 5.1 хувь, гар тэжээл 14.0 мян.т буюу 42.8 хувиар нэмэгдсэн байна.

Хураасан ургацын хэмжээ нэмэгдэхэд өмнөх оныхоос үр тариа тариалсан талбайн хэмжээ Дархан-Уул, Дорнод, Төв, Сэлэнгэ аймагт 4.2-22.4 мян.га, төмс тариалсан талбайн хэмжээ Ховд, Сэлэнгэ, Төв аймагт 0.2-0.8 мян.га, хүнсний ногоо тариалсан талбайн хэмжээ Ховд, Төв, Сэлэнгэ аймагт 0.2-0.3 мян.га-гаар өссөн нь нөлөөллөө.

Га тутмаас 14.9 цн үр тариа, 131.1 цн төмс хураасан нь өмнөх оныхоос үр тариа 1.2 цн буюу 8.6 хувь, төмс 9.5 цн буюу 7.9 хувиар их байна. Үр тарианы га-гийн ургац Булган, Дархан-Уул, Хөвсгөл, Төв, Орхон, Баянхонгор, Баян-Өлгий аймагт улсын дунджаас 0.3-10.5 центнерээр их, харин бусад аймагт 0.5-9.0 центнерээр бага байна.


Төмсний га-гийн ургац Ховд, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт улсын дунджаас 2.1-34.7 центнерээр их, харин нийслэл болон бусад аймагт 1.5-104.7 центнерээр бага байна.

Хураасан үр тарианы 49.1 хувь нь Сэлэнгэ, 24.1 хувь нь Төв, 10.0 хувь нь Булган, 5.2 хувь нь Хөвсгөл; төмсний 32.7 хувь нь Төв, 27.5 хувь нь Сэлэнгэ, 7.1 хувь нь Дархан-Уул, 7.0 хувь нь Ховд, 4.5 хувь нь Булган аймагт ногдож байна.

Бүсээр авч үзэхэд хураасан үр тарианы 2.3 хувь нь Баруун, 3.1 хувь нь Зүүн, 17.6 хувь нь Хангайн, 77.0 хувь нь Төвийн бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы хэмжээ өмнөх оныхоос Баруун бүсэд 2.4 мян.т буюу 31.2 хувь, Хангайн бүсэд 13.7 мян.т буюу 21.1 хувь, Төвийн бүсэд 73.5 мян.т буюу 27.2 хувь, Зүүн бүсэд 1.4 мян.т буюу 11.3 хувиар өслөө.


Зураг-III.12

Үр тариа, төмс, хүнсний ногоо хураалт, мян.т, жил бүрийн эцэст



Зураг-III.13

Бэлтгэсэн хадлан, мян.т жил бүрийн эцэст



Хүснэгт-III.1

Улаан буудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, нөөцийн харьцаа (2011 оны байдлаар)

	Үйлдвэрлэл			Импорт		
	2009	2010	2011	2009	2010	2011
Улаан буудай	388,1	345,5	435,9	112,8	66,1	7,3
Төмс	151,2	168,0	201,6	23,2	8,5	5,8
Хүнсний ногоо	78,0	82,3	99,0	52,3	49,9	69,3

	Нийт нөөц			Үйлдвэрлэл/Нөөц (%)		
	2009	2010	2011	2009	2010	2011
Улаан буудай	388,1	345,5	435,9	112,8	66,1	7,3
Төмс	151,2	168,0	201,6	23,2	8,5	5,8
Хүнсний ногоо	78,0	82,3	99,0	52,3	49,9	69,3



Хураасан нийт хүнсний ногооны 34.9 мян.т буюу 35.2 хувь нь Сэлэнгэ аймаг, 13.1 мян.т буюу 13.3 хувь нь Дархан-Уул аймаг, 12.9 мян.т буюу 13.0 хувь нь Төв аймаг, 10.4 мян.т буюу 10.5 хувь нь Ховд аймаг, үлдсэн 27.7 мян.т буюу 28.0 хувь нь нийслэл болон бусад аймагт ногдож байна.

Бэлтгэсэн нийт хадлангийн 203.2 мян.т

буюу 17.0 хувь нь Хөвсгөл аймагт, 164.0 мян.т буюу 13.7 хувь нь Сэлэнгэ аймагт, 126.2 мян.т буюу 10.6 хувь нь Хэнтий аймагт, 107.5 мян.т буюу 9.0 хувь нь Булган аймагт, 90.6 мян.т буюу 7.6 хувь нь Төв аймагт, 85.1 мян.т буюу 7.1 хувь нь Архангай аймагт, 71.1 мян.т буюу 5.9 хувь нь Ховд аймагт, үлдсэн 347.5 мян.т буюу 29.1 хувь нь нийслэл болон бусад аймагт ногдож байна.

I.4 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2011 онд 2056.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 182.2 тэрбум төг буюу 9.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд газрын тос, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 16.8-77.3 хувь, нарийн боов, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, малын мах, талх, амтат ус, ундаа, шингэн сүү, тамхи, архи, жүүс, шар айраг, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.8-86.5 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.


Харин зэсийн баяжмал, металл агуулгаараа, алт, буталмал чулуу, цайрын баяжмал, молибдений баяжмал, хайлуур жоншны баяжмал зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.6-17.3 хувь, өлөн гэдэс, спирт, металл бэлдэц, шохой, металл цувимал, катодын зэс, зүсмэл материал, гурил, цул бетон, малын тэжээл, тарилгын эм зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.9-96.1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2011 онд 5027.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 941.1 тэрбум төг буюу 23.0 хувиар өссөн бөгөөд үүний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 665.6 тэрбум төг буюу 23.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 240.0 тэрбум төг буюу 27.3 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 35.5 тэрбум төг буюу 9.5 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2011 онд оны үнээр 5626.7 тэрбум төг болж, үүний 3513.8 тэрбум төг буюу 62.4 хувийг гадаад зах зээлд борлуулжээ (Хавсралт 9).


Зургаг-III.14

Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, бууралт, жил бүрийн эцэст, хувиар, 2005=100%



Зургаг-III.15

Түлш, эрчим хүчний гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, жил бүрийн эцэст, хувиар, 2005=100%





Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 64.9 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 27.8 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 7.3 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна (Зураг 16). Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2011 онд 3651.2 тэрбум төг болж, 3059.0 тэрбум төг буюу 83.8 хувийг, боловсруулах аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 1566.8 тэрбум төг болж, 454.8 тэрбум төг буюу 29.0 хувийг нь гадаад зах зээлд борлуулав.


Нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2011 онд 27.8 хувь болж, өмнөх оныхоос 6.8 пунктээр нэмэгдэж, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 64.9 хувь болж, 5.7 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 7.3 хувь болж, 1.1 пунктээр буурлаа (Зураг 16).

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2011 оны 12 дугаар сарын эцэст 56797 болж, өмнөх оныхоос 2508 хүн буюу 4.6 хувиар өсчээ. Ажиллагчдын тоо уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 98 хүн буюу 0.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2202 хүн буюу 9.3 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 208 хүн буюу 1.5 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр)

Зураг-III.16

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн эцэст, хувиар



2011 онд 37775.7 мян.төг болж, өмнөх оныхоос 1281.2 мян.төг буюу 3.5 хувиар өсчээ. Хөдөлмөрийн бүтээмж уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1769.8 мян.төг буюу 2.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 694.5 мян.төг буюу 2.7 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 786.2 мян.төг буюу 5.0 хувиар өслөө.

III.5 Барилга


Барилга угсралт, их засварын ажил 2011 онд 450.7 тэрбум төг болж, 427.9 тэрбум төг буюу 94.9 хувь нь дотоодын, 22.8 тэрбум төг буюу 5.1 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна (Хүснэгт III.2, Зураг III.17).

Барилга угсралт, их засварын ажил өмнөх оныхоос 99.9 тэрбум төг буюу 28.5 хувиар өсөхөд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажил 101.4 тэрбум төг буюу 31.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Харин гадаадын байгууллагын гүйцэтгэсэн ажил 1.5 тэрбум төг буюу 6.3 хувиар буурлаа (Хүснэгт III.3).

Нийт гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын 33.3 хувь нь инженерийн барилга байгууламж, 29.8 хувь нь орон

Зураг-III.17

Барилга угсралт, их засварын ажил (тэрбум төгрөг)






сууцны барилга, 27.4 хувь нь орон сууцны бус барилга, 9.5 хувь нь их засварын ажил байна.

Зураг-III.18

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын 55.8 хувь нь Улаанбаатар хотод, 4.9 хувь нь Хөвсгөл, 4.8 хувь нь Орхон, 4.5 хувь нь Увс, 3.2 хувь нь Ховд, 2.7 хувь нь Дархан-Уул аймагт ногдож байна. Барилга угсралт, их засварын ажил Булган, Сэлэнгэ, Дорноговь, Увс, Хөвсгөл аймагт өмнөх оныхоос 2.4-6.0 дахин өссөн байна. Харин өмнөх онуудад нилээд өсөлттэй байсан Говь-Алтай аймагт барилга угсралт, их засварын ажил өмнөх оныхоос 47.9 хувиар буурсан байна.

Барилга угсралт, их засварын ажил, улирлаар (тэрбум төгрөг)



Хүснэгт-III.2

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, оны үнээр

Гүйцэтгэгчийн төрөл	2009	2010	2011	тэрбум төг.
				$\frac{2011}{2010}$ %
Барилга угсралт, их засварын ажил, бүгд	279,4	350,8	450,7	128,5
Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	250,6	326,5	427,9	131,1
Гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	28,8	24,3	22,8	93,7

Хүснэгт-III.3

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, оны үнээр

тэрбум төг.

Гүйцэтгэгчийн төрөл	2009				2010				2011			
	I	I-II	I-III	I-IV	I	I-II	I-III	I-IV	I	I-II	I-III	I-IV
Барилга угсралт, их засварын ажил, бүгд	21,0	66,9	145,4	279,4	8,4	55,9	143,7	350,8	23,0	97,5	258,1	450,7
Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	19,4	62,3	124,8	250,6	4,0	49,0	131,0	326,5	22,4	95,5	240,1	427,9
Гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	1,6	4,6	20,6	28,8	4,4	6,9	12,8	24,3	0,7	2,0	18,0	22,8

III.6 Дотоод худалдаа

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувь, борлуулалтын нийт орлогын 90.0 гаруй хувийг жилд 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж эзэлж байна.

онд 3231.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1155.7 тэрбум төг буюу 55.7 хувиар өсчээ.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт (оны үнээр) 2011

Энэ нь импорт өмнөх оныхоос 3326.8 сая ам.долл, үүний дотор машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 1090.8 сая ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд



ангийн бүлгийн импорт 888.9 сая ам.долл, эрдэс бүтээгдэхүүний импорт 498.2 сая ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 383.7 сая ам.долл, хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэлийнх 119.0 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 89.2 сая ам.доллараар өссөнөөс голлон шалтгаалав.

Өмнөх оныхоос бөөний худалдааны борлуулалт 1072.0 тэрбум төг буюу 75.2 хувиар, жижиглэн худалдааных 83.8 тэрбум төг буюу 12.9 хувиар өслөө (Зураг III.19).

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын борлуулалтын 85.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Салбарын нийт борлуулалтын 77.3 хувийг бөөний, 22.7 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт өмнөх оныхоос Дорнод аймагт 0.4 хувиар буурч, Улаанбаатар хот болон бусад бүх аймагт 1.2 хувиас 2.7 дахин өсчээ.

Жилийн 5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн худалдааны ашигтай талбай 2011 онд дунджаар 2295.3 ам метр байгаа бол 100 сая төгрөгөөс бага орлоготой жижиг аж ахуйн нэгжийнх 70.3 ам метр байна. (Хүснэгт III.4)

Жилийн 5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой худалдааны томоохон төвүүдэд нэг ам метр талбайд ногдох дундаж орлого 12.1 сая төг байгаа бол харин 100 сая төгрөгөөс бага борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ үзүүлэлт 428.1 мян.төг байна (Хүснэгт III.5).

Худалдааны салбарын ажлын цагийн үргэлжлэх хугацаа нийт аж ахуйн нэгжийн 1.3 хувьд нь 8 хүртэл цаг, 94.9 хувьд нь 8-10 цаг, 3.8 хувьд нь 24 цаг байна.


Худалдааны салбарт ажиллаж байгаа нийт ажиллагчдын 51.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

III.7 Тээвэр

Бүх төрлийн тээврээр 2011 онд 44.0 сая т ачаа, давхардсан тоогоор 296.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оныхоос тээсэн ачаа 14.5 сая т буюу 49.5 хувь, зорчигчдын тоо 45.5 сая хүн буюу 18.2 хувиар нэмэгджээ.

Авто тээврээр 2011 онд 25.6 сая т ачаа, давхардсан тоогоор 291.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оныхоос тээсэн ачаа 13.0 сая т буюу

Зураг-III.19
Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт, жил бүрийн эцсийн байдлаар, тэрбум төг



Хүснэгт-III.4

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт, жил бүрийн эцсийн байдлаар

Дэд салбар	2009	2010	2011	$\frac{2011}{2010}$ %
Бүгд	1278 224,0	2075 545,7	3 231 266,4	155,7
Бөөний худалдаа	871 770,2	1424 824,9	2496 787,5	175,2
Жижиглэн худалдаа	406 453,5	650 720,8	734 478,9	112,9

Хүснэгт-III.5

Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн ашигтай талбайн хэмжээ, борлуулалтын орлогын бүлгээр,

Борлуулалтын орлого, бүлгээр	Ашигтай талбайн нийт хэмжээ (м ²)	Нэг аж ахуйн нэгжид ногдох ашигтай талбай (м ²)	Ашигтай талбайн нэг м ² -д ногдох дундаж орлого (мян.төг)
100 сая төг хүртэл	50 482,3	70,3	428,1
101-500 сая төг	62 182,9	174,2	1 341,4
501-1000 сая төг	24 400,5	223,9	3 217,3
1001-5000 сая төг	38 047,6	273,7	7 719,7
5001 сая төгрөгөөс дээш	227 230,0	2 295,3	12 120,0

2.0 дахин, зорчигчдын тоо 45.0 сая зорчигч буюу 18.2 хувиар нэмэгджээ. Авто тээврийн орлого өмнөх оныхоос 33.3 тэрбум төг буюу 19.3 хувиар өссөн байна.

Авто техникийн улсын үзлэг, тооллогын дүнгээр 2011 онд 312.5 мянган авто машин тоологдсон нь өмнөх оныхоос 58.1 мянга буюу 22.8 хувиар нэмэгджээ.



Авто машины 66.7 хувийг суудлын автомашин, 24.0 хувийг ачааны автомашин, 7.2 хувийг автобус, 2.1 хувийг тусгай зориулалтын автомашин эзэлж, өмнөх оныхоос суудлын авто машины эзлэх хувь 1.1 пункт, ачааны автомашиных 0.3 пунктээр буурч, автобусных 0.8 пункт, тусгай зориулалтын автомашиных 0.6 пунктээр өссөн байна.

2010 онд тоологдсон нийт авто машины 3.4 хувийг 3 хүртэл жил, 21.3 хувийг 4-9 жил, 75.3 хувийг 10-аас дээш жил ашигласан автомашин эзэлж байсан бол 2011 онд 3.4 хувийг 3 хүртэл жил, 14.8 хувийг 4-9 жил, 81.8 хувийг 10-аас дээш жил ашигласан автомашин эзэлж байна.

10-аас дээш жил ашигласан авто машины хувийн жин 2011 онд өмнөх оныхоос 6.5 пунктээр нэмэгджээ.

Төмөр замын тээврээр 2011 онд 18327.4 мян.т ачаа, давхардсан тоогоор 3829.0 мян. зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос тээсэн ачаа 1523.4 мян.т буюу 9.1 хувь, зорчигчдын тоо 312.7 мян.хүн буюу 8.9 хувиар өссөн байна (Зураг III.20.а, III.20.б).


Төмөр замаар тээвэрлэсэн нийт ачааны хэмжээ өмнөх оныхоос 1523.4 мян.тонноор өсөхөд дамжин өнгөрсөн ачааны хэмжээ 426.4 мян.т буюу 18.4 хувиар буурсан хэдий ч экспортын ачааны тээвэрлэлт 1309.2 мян.т буюу 28.2 хувь, импортын ачаа 481.0 мян.т буюу 31.1 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо 2011 оны 12 дугаар сард 289.0 мян.хүн болж, өмнөх сарынхаас 50.0 мян.хүн буюу 14.8 хувь, тээсэн ачаа 1544.2 мян.т болж, 37.9 мян.т буюу 2.4 хувиар буурч, харин тээврийн орлого 36.4 тэрбум төг болж, 6.1 тэрбум төг буюу 20.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс тээврийн орлого 0.9 тэрбум төг буюу 2.6 хувь, зорчигчдын тоо 12.2 мян.хүн буюу 4.4 хувь, тээсэн ачаа 22.7 мян.т буюу 1.5 хувиар өсчээ.


Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөс төмөр замын тээврийн салбарын орлого 2011 онд 390.5 тэрбум төг болж, өмнөх оныхоос 83.6 тэрбум төг буюу 27.2 хувиар өсчээ (Хүснэгт III.6).

Хүснэгт-III.6

Зураг-III.20.а
Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эцсийн байдлаар, мян.т



Зураг-III.20.б
Төмөр замын тээврээр тээсэн зорчигчдын тоо, жил бүрийн эцсийн байдлаар, мян.хүн



Төмөр замын тээврийн орлого, тээсэн ачаа болон зорчигчдын тоо, сараар			
Хугацаа, сараар	Тээврийн орлого, сая төг	Зорчигчдын тоо, мян.хүн	Тээсэн ачаа, мян.т
2009 I	13 278.5	250.9	1 034.7
II	17 159.6	262.2	966.4
III	12 379.4	247.4	1 114.6
IV	17 200.0	235.8	1 113.8
V	24 184.2	274.2	1 224.3
VI	20 030.5	290.4	1 076.1
VII	20 015.9	289.1	1 161.5
VIII	14 229.0	344.7	1 205.2
IX	27 635.1	248.0	1 286.8
X	20 169.4	256.5	1 312.8
XI	18 378.8	164.4	1 323.7
XII	21 757.0	254.9	1 351.7
2009 I-XII	226 417.4	3 118.3	14 171.5
2010 I	19 860.5	257.9	1 277.8
II	18 766.2	294.5	1 169.5
III	21 037.8	248.3	1 198.9
IV	21 538.6	259.7	1 222.3
V	24 687.0	301.1	1 268.5
VI	26 479.8	316.3	1 366.0
VII	27 888.0	316.6	1 434.2
